


# ТАЙЛАН 2017/2018



Хараат бус

Чанартай

Үр нөлөөтэй

# АГУУЛГА

1	Бидний үзүүлдэг үйлчилгээ	2
2	Өмнөх үг	3
3	Бидний тухай	4
4	IRIM тоогоор	5
5	IRIM-ийн 10 жилийн онцлох үйл явдал	6
6	Салбарын онцлох төслүүд	7
7	IRIM-ийн 2017 оны онцлох үйл явдал	11
8	2017 оны онцлох үйл явдал	12
9	IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төслүүд	14
	1. Монголын нийгмийн нягтрал, субъектив сайн сайхан байдлын судалгаа	14
	2. "АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг монголд нэвтрүүлж, нутагшуулах" төсөл	18
	3. Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал	20
10	Хэрэгжүүлсэн төслүүд	24
	4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй	24
	5. Эрх зүйт ёс ба Монголын уул уурхайн салбар дахь байгаль орчны засаглал	28
	6. "Говийн оюу" хөгжлийг дэмжих сангийн чадавхийг бэхжүүлэх, засаглалыг сайжруулах зөвлөх үйлчилгээ	31
	7. Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлд хийсэн нөхцөл байдлын шинжилгээ	34
	8. Үр дүнд суурилсан нэгдсэн менежментийг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ	37
	9. Монгол дахь арьс ширний үйлдвэрлэлийн судалгаа	40
	10. Төрийн үйлчилгээний төвлөрөлийг сааруулах тухай иргэдийн санал бодлын судалгаа	42
	11. Байгаль орчны салбарын жендэрийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ (ойн салбарын жишээ)	45
	12. "Зэлүүд тал II: Монголын зэрлэг ан амьтны хууль бус худалдаа" төслийн III дахь шатны судалгаа	50
	13. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ	53
	14. Дээд боловсролын хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үр дүнг түгээх зөвлөх үйлчилгээ	55
	15. "Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь" төслийн эцсийн үнэлгээ	58
11	Хэрэгжиж буй төслүүд	60
	16. Нийслэлийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, баримтлах журам, төслийн удирдлагыг сайжруулах аргачлал боловсруулах	60
	17. "21-р зууны ардчилал: сорилтууд ба цаашдын хандлага" сэдэвт олон улсын бага хурал	62
	18. Бизнесийн ёс зүйт байдлын хөтөлбөрийн судалгаа	65
	19. Нийгмийн халамжийн зардлын өөрчлөлт, төсвийн бууралтын үр нөлөөний шууд мониторинг	67

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа зөвлөх үйлчилгээ хүргэдэг Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв болно.

## ЧАНАРЫН БОДЛОГО

Олон улсын стандарт, захиалагчийн хэрэгцээнд нийцсэн, хараат бус судалгааны үйлчилгээ үзүүлдэг, тогтвортой хөгжих байгууллага байна.

## БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

ТУРШЛАГА:

**СУДАЛГАА** - Бид мэргэжлийн, шинжлэх ухаанч арга зүйгээр олон салбар хамарсан судалгааны ажлын туршлагатай. Тоон ба чанарын аргыг ашиглан шинэлэг, салбар хоорондын судалгааны төслийн дизайныг боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Судалгааны мэдээллийн найдвартай байдалд чанарын хяналт тавьж, үр дүнг сүүлийн үеийн судалгааны мэдээлэл боловсруулах программ дээр гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийн үр дүнг боловсруулж байна.

89  
ТӨСӨЛ

**ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ** - Хяналт, үнэлгээний ажлууд манай байгууллагын гүйцэтгэж буй ажлын гуравны нэг орчим хувийг эзэлдэг. Бид Засгийн газар болон Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрүүдэд хараат бус, хөндлөнгийн шинжилгээ хийж, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу баримт нотолгоонд суурилсан дүгнэлт гаргахыг эрмэлздэг.

51  
ТӨСӨЛ

Манай байгууллага нь Монголын Үнэлгээний Сүлжээг санаачлагчдын нэг бөгөөд гишүүдийн хамтаар Үндэсний Үнэлгээний стандартыг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

**СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ** - Бид сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахдаа олон төрлийн аргачлал, арга зүйг ашиглахаас гадна өөрсдийн туршлагаараа байнга баяжуулж, шинэчилдэг. Сургалтууд нь төсвийн нээлттэй байдал, иргэдийн оролцоо, байгууллагын чадавхийг бэхжүүлэх зэрэг олон сэдвийг хамардаг. Бид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа оролцооны, интерактив аргачлал ашигладаг ба зохион байгуулалт, оролцогчдын хэрэгцээний үнэлгээ, сургалтын материал, модулийн боловсруулалт, баримтжуулалт (зураг, тэмдэглэл гэх мэт) болон сургалт бүрийн төгсгөлд сэтгэл ханамжийн судалгаа хийж цаашид сайжруулах боломж, үр дүнг үнэлдэг.

15  
ТӨСӨЛ

**ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ** - Манай байгууллагын хэрэгжүүлдэг төслүүд судалгаагаар хязгаарлагддаггүй. Бид бодлогын түвшний шийдвэр гаргагчдад нөлөөлөх төрөл бүрийн арга зүйн зөвлөх үйлчилгээ болон нөлөөллийн төслүүд төлөвлөн, хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хөгжлийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, арга зүй, санал зөвлөмж дэвшүүлэх;
- Байгууллагын дотоод гадаад орчны шинжилгээ хийх, чадавхижуулах стратеги боловсруулах зэрэг үйлчилгээнүүд үзүүлдэг.

16  
ТӨСӨЛ



Онц бөгөөд бүрэн эрхт элчин  
сайд, IRIM-ийн Ерөнхийлөгч  
Х.Бэхбат



Гүйцэтгэх захирал  
Ц.Батсугар

Монгол Улс эдийн засгийн уналтаа зогсоож, гадаад өрийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг сэргээсэн амжилттай 2018 онтой золголоо. Гэсэн хэдий ч манай орны хувьд тогтвортой хөгжлийн зорилтууддаа хүрэхэд шийдвэрлэх асуудал их байна.

Эдийн засгийн хүрээнд ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ингэхдээ хөдөлмөрийн зах зээл дэх зорилтот бүлгийн иргэдийн тэгш оролцоог нэмэгдүүлэх, уул уурхайн баялгийн хуваарилалтын хууль эрх зүйн орчин, засаглалыг сайжруулах тулгамдсан хэрэгцээ шаардлага байсаар байна.

Нийгмийн асуудлын хүрээнд төрийн чадавхыг бэхжүүлж сайн засаглалыг хөгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн болон эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулах сорилттой тулгарч байна. Мөн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд байгаль орчныг хамгаалах талаар иргэдийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, байгальд ээлтэй зан үйлийг дэмжих, ялангуяа уул уурхайн, аж үйлдвэр, суурин газрын нөлөөллийн бүс дэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын хууль эрх зүйн орчныг талуудын оролцоотойгоор сайжруулж, оролцогч талууд, төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх нь чухал байна.

Эдгээр хөгжлийн зорилтод хүрэхэд төр хувийн хэвшлийн түншлэл, бүх талуудын хамтын ажиллагаа, тэдний үйл ажиллагааны уялдааг хангах нь нэн чухал ач холбогдолтой юм. Үүний нэг төлөөлөгч болох IRIM судалгааны хүрээлэн 2008 онд байгуулагдсанаасаа хойш сүүлийн 10 жилд Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийг хараат бус, мэргэжлийн судалгаа, үр дүнд суурилсан үнэлгээгээр хангаж, хөгжлийн бодлогыг уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэн

ажиллаж байна. Түүнчлэн Жендэрийн Үндэсний Хорооны гишүүнээр сонгогдон ажиллалаа. Мөн төрийн бүх шатны байгууллага, хөгжлийн түншүүд, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэв. Тухайлбал, 2017 онд бид бүх төвшинд нотолгоонд суурилсан хөгжлийн төлөвлөлт, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээг бэхжүүлэхэд гар бие оролцон ЗГ-ийн ХШҮ –ний ажлыг хэрэгжүүлэх нутгийн удирдлагын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ДБ-тай хамтран ажиллалаа. Түүнчлэн Монголд үнэлгээний стандартын ерөнхий хүрээг нутагшуулах ажлыг Олон Улсын Үнэлгээний Хамтын Ажиллагааны Байгууллагын дэмжлэгтэй эхлүүлээд байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн түвшинд эрт илрүүлэх, тэгш хамран сургах чадавхыг бэхжүүлэх, талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, байгаль орчны салбар дахь жендэрийн тэгш байдлыг хангах зэрэг нийгмийн асуудлаар олон улсын болоод төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж сайн туршлагын хуримтлуулан бусдад түгээн дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Монголын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Ази Номхон Далайн Үнэлгээний Байгууллагад элсэж удирдах зөвлөлийн гишүүнээр, Олон Улсын Субъектив Сайн Сайхан Байдлын Түншлэл, Өөрчлөлтийн Төлөө Инноваци санаачилгын төв азийн бүлэгт тус тус гишүүнээр элсэн ажиллаж байна.

Эцэст нь хэлэхэд, эдгээр бүх ажил үйлс нь бидэнд итгэсэн, захиалагчид, хараат бус, мэргэжлийн, эерэг өөрчлөлтийг бий болгох чин эрмэлзэлтэй зөвлөх, судлаачид, хамтран ажиллагч салбар бүрийн мэргэжилтнүүдийн хамтын амжилт юм.

Бид уламжлал ёсоор энэхүү тайлангаа Монголын хөгжлийн асуудлаар сонирхон судалдаг хэн бүхэн, шийдвэр гаргагчид, хөгжлийн салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдэд IRIM-ийн хэрэгжүүлсэн төслүүд, тэдгээрийн үр дүнгийн талаар мэдээлэл болох үүднээс бэлтгэн хүргэж байна.

Хөгжлийн төлөөх та бүхний үйлс улам өөдрөг байг!

## БИДНИЙ ТУХАЙ



IRIM Судалгааны Хүрээлэн нь 2008 оны 4-р сард дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулагдсан.


Бид төслийн удирдлага, сургалт, судалгаа, үнэлгээний чиглэлээр төрийн болон төрийн бус, олон улсын болон донор байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмрээ оруулахаар зорьж ажиллаж байна.

Бид өөрийн орны онцлогийг тусгасан, үр дүнг чухалчилсан, үйлчлүүлэгч төвтэй төслийн менежментийн шийдлүүдийг санал болгохоос гадна нотолгоонд суурилсан чанартай мэдээлэл бий болгох, хараат бус, хөндлөнгийн байр сууриа хадгалах зарчмыг үргэлж баримталдаг.

Манай байгууллагын гүйцэтгэсэн зөвлөх үйлчилгээ, судалгааны ажил нь өргөн хүрээний асуудлуудыг хамардаг, түүн дотроо засаглал, боловсрол, хөдөлмөрийн зах зээл болон уул уурхайн салбарт илүүтэй төвлөрч байна.

Бид одоогийн байдлаар 24 үндсэн, 20 гаруй гэрээт ажилтантай ба манай мэдээллийн санд үндэсний болон олон улсын 300 гаруй зөвлөх бүртгэлтэй байдаг. Байгуулагдсан цагаасаа хойш MIRIM (Marketing and Innovation Research Institute of Mongolia) буюу МИРИМ Консалтант гэсэн охин компанийг маркетинг, инновацийн судалгааны чиглэлээр үүсгэн байгуулж, ажиллаж байна.

# IRIM ТООГООР



**2008** ОНЫ  
4 сар

**2018** ОНЫ  
4 сар

**74**

Засаглал

**26**

Боловсрол

**22**

Уул уурхай,  
байгаль орчин

**10**

Хөдөлмөрийн  
зах зээл

**31**

Бусад

**132886**  
Респондент




**86** Захиалагч




**142** Хамтрагч

## ТӨСӨЛХЭРЭГЖСЭН ГАЗРУУД



Улаанбаатар	124	Увс	33	Завхан	28
Ховд	47	Сэлэнгэ	33	Сүхбаатар	26
Өмнөговь	40	Дорнод	32	Орхон	27
Дархан-Уул	37	Хөвсгөл	32	Баян-Өлгий	25
Дорноговь	35	Хэнтий	29	Говьсүмбэр	21
Баянхонгор	35	Архангай	29	Булган	18
Говь-Алтай	34	Төв	27	БХНАУ-ын Эрээн хот 1	
Өвөрхангай	33	Дундговь	27	<b>Нийт 761</b>	



- Олон улсын байгууллага
- Төрийн байгууллага
- Төрийн бус байгууллага
- Хувийн байгууллага, иргэн

## Бидний ёс зүйн болон мэргэжлийн зарчим



Олон Улсын Социологичдын Холбоонд (ISA) 2011 оноос хойш Монгол улсаас албан ёсны гишүүн бөгөөд тус байгууллагаас батлан гаргасан "Ёс зүйн дүрэм"-ийг чанд сахин ажилладаг.



2016 оны 8 сард "Ази-Номхон далайн Үнэлгээний Холбоо"-нд албан ёсоор нэгдэн орсон Монголын анхны байгууллага юм. Мөн 2017 оноос тус холбооны ТҮЗ-ын гишүүн байгууллагаар сонгогдон ажиллаж байна.



IRIM нь Монголын үнэлгээний сүлжээг байгуулах санаачилгыг эхлүүлсэн бөгөөд энэ чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус, ОУ-ын байгууллагын мэргэжилтэн, зөвлөхүүдийг эгнээндээ нэгтгэсэн. Одоогоор сүлжээний гишүүдтэйгээ хамтран Үндэсний үнэлгээний стандартыг Монголдөө нэвтрүүлэхээр ажиллаж байна.



IRIM нь 2016 оноос "Субъектив сайн сайхны судалгаа"-г санаачлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2017 оны 10 дугаар сард "Азийн Субъектив сайн сайхан байдал олон улсын консорциум"-д Монгол Улсыг төлөөлөн гишүүнээр нэгдэн орсон.



ЖЕНДЕРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

Монгол Улсын Жендерийн Үндэсний Хорооны орон тооны гишүүнээр 2017 оноос ажиллаж байна. Энэ хүрээнд нийгмийн бүхий л салбарт, жендерийн тэгш эрхийг хангуулах, төрийн бодлогод жендерийн тэгш эрхийн зарчмыг хангуулах тал дээр иргэний нийгэм, хувийн хэвшлийг төлөөлөн ажиллаж байна.



Ази номхон далайн үлс орнуудын "Нийгмийн хариуцлагын төлөх сүлжээ" байгууллагын гишүүнээр 2010 оноос хойш ажиллаж байна.



# IRIM-ИЙН 10 ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Үүсгэн байгуулагдсан жил

2008

IRIM Судалгааны Хүрээлэн нь Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн их сургуулийн багш, төгсөгчдийн санаачлагаар 2008 онд үүсгэн байгуулагдсан зөвлөх үйлчилгээний компани юм. Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Монгол Улсад хөгжлийн оновчтой бодлого гаргах, төр, хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг сайжруулах, түүний амин сүнс болсон иргэд, олон нийтийн оролцоог бэхжүүлэхэд тууштай зөвлөх ажиллаж ирлээ.

## Нийгмийн эгэх хариуцлагын асуудлыг хөндөж эхэлсэн жил

2010

Манай хүрээлэн Нийгмийн Эгэх Хариуцлагын Азийн Сүлжээ (ANSA)-ний гүйцэтгэх хорооны гишүүн байгууллага болов. Улмаар Монгол Улсад анх удаа "Нийгмийн Эгэх Хариуцлагын Зураглал" гаргах төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү санаачлага өнөөг хүртэл үргэлжлэж, Монгол Улсын боловсрол, Эрүүл мэндийн салбарын эгэх хариуцлагыг сайжруулах төсөлд Дэлхийн Банктай 2016-2018 онд хамтарч ажиллаж байна.

## Хүний нөөцийн чадавхи, үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлсэн жил

2012

Австрали Улсын Засгийн Газраас хэрэгжүүлдэг "Олон Улсын Хөгжлийн Төлөөх Сайн Дурын Ажилтан"-г анх удаа хүлээн авлаа. Сайн дурын ажилтан зургаан сараас нэг жилийн хугацаанд тухайн байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр ажилладаг ба өнгөрсөн хугацаанд дөрвөн сайн дурын ажилтныг хүлээн авсан.

Үүний сацуу, тус онд Монгол Улсын нийгмийн халамжийн салбарт хийгдсэн гол шинэчлэлт болох хавтгайрсан нийгмийн халамжийг зорилтот бүлэг рүү чиглүүлэх төсөлд оролцож, анх удаа улсын хэмжээнд халамжийн зорилтот бүлгийг тодорхойлох "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тооцох төсөл"-өөр гурван аймгийн 40 гаран мянган өрхийг бүртгэж судалсан нь байгууллагын туршлагыг тэлсэн нэг чухал алхам байв.

## Хараат бус байдал, үйл ажиллагаа бэхжүүлсэн жил

2014

IRIM Судалгааны Хүрээлэн нь хээл хахууль, хүнд суртлаас ангид үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэж, сайн засаглалыг бий болгоход чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг олноор хэрэгжүүлэв. Үүний үр дүнд салбартаа үлгэр дууриалал болж байгааг үнэлж Авлигатай Тэмцэх Газраас "Авлигаас ангид, сайн засаглалын сайн санаачилга-2014" уралдаанд шалгаруулж, шагнал олгосон билээ.

Мөн тус онд өөрсдийн салбар чиглэлийг өргөтгөн маркетинг, инновацийн судалгааны МИРИМ Консалтант охин компаниа байгуулав. МИРИМ Консалтант нь хувийн хэвшлийн салбарын онцлог, хэрэгцээнд нийцсэн судалгааны ажлыг мэргэжлийн зөвлөхүүд, баг бүрэлдэхүүнээр гүйцэтгэн ажиллаж байна.

## Монголын Үнэлгээний стандартыг хөгжүүлэх санаачлагын жил

2016

Байгууллагын үйлчилгээний гол чиглэлийн нэг нь хяналт-үнэлгээ ба энэ чиглэлээр Монголын Үнэлгээний Сүлжээг санаачлан байгуулав. Одоогоор сүлжээний гишүүдтэйгээ хамтран Үндэсний үнэлгээний стандартыг Монголдоо нэвтрүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн тус онд манай байгууллага албан ёсоор Ази Номхон Далайн Үнэлгээний Холбоонд нэгдэн орсон Монголын анхны байгууллага болов. Ингэснээр хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээрх бидний туршлагыг олон улсын түвшинд үнэлүүлэх боломж гарсан билээ.

2009

## Засаглалын чиглэлээрх үйл ажиллагаагаа бэхжүүлсэн жил

Байгууллагын үндсэн стратегийн салбар болох засаглалын чиглэлд үйл ажиллагаагаа бэхжүүлэх эхлэл тавигдаж, томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхлэв. Тухайлбал, төсвийн ил тод байдлын чиглэлээр "Шилэн түрийвч", "Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал" зэрэг төслүүдийг хэрэгжүүлснээс гадна, төрийн болон орон нутгийн төрийн бус байгууллагыг чадавхижуулах зөвлөх үйлчилгээний төслүүдийг эхлүүлсэн.

2011

## Монголын социологийн хөгжлийг төлөөлөгч байгууллага болсон жил

Монгол Улс дахь социологийн шинжлэх ухаан, судалгааны байгууллагуудын төлөөлөл болон Олон Улсын Социологийн Холбоо (ISA)-ны албан ёсны гишүүнээр элсэв. Ингэснээр өөрсдийн хэрэгжүүлсэн бүхий л судалгаа, шинжилгээний ажилд уг холбооны Гүйцэтгэх зөвлөлөөс баталсан "Ес зүйн дүрэм"-ийг чанд баримтлан ажилласаар ирлээ. Түүнчлэн, Монголын нийгмийн амьдралд тулгамдаж буй олон асуудалд өөрсдийн хийсэн социологийн судалгаа, дүн шинжилгээг тус холбооны дөрвөн жил тутмын чуулга уулзалт, жил тутмын хурал цугларалтад олон орны судлаачдад танилцуулж, хэлэлцүүлж ирсэнийг онцлон тэмдэглүүштэй.

2013

## Хяналт-шинжилгээ, үнэлгээний туршлагаа бэхжүүлсэн жил

Олон улсын болон төрийн байгууллагын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх туршлагаа бэхжүүлэв. Тухайлбал, олон улсын байгууллагаас "Швейцарийн Хөгжлийн Агентлагийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр (2013-2016)", "Нэг Цонхны Үйлчилгээ" төслүүд, төрийн байгууллагаас УБЕГ болон ЦЕГ-ын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Эдгээр хяналт, үнэлгээний ажлууд нь тухайн төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, алдаанаасаа суралцах, дараагийн төсөл хөтөлбөрийг илүү оновчтой төлөвлөхөд хувь нэмэр оруулж ирсэн.

2015

## Гадаад харилцааг бэхжүүлсэн жил

Байгууллагын гадаад харилцааг бэхжүүлэх, түншлэгч байгууллагуудад таниулах ажлыг 2015 оноос эрчимжүүлж ажиллав. Үүний хүрээнд хийгдэж буй нэг томоохон ажил нь 2015 оноос хойш байгууллагын нэрэмжит "Оны хүлээн авалт"-ыг жилийн төгсгөл арванхоёрдугаар сард зохион байгуулсаар ирлээ. Өнгөрсөгч 2017 оны хүлээн авалтаар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 193 гишүүн орон 2030 он гэхэд хүрсэн байхаар амалсан Тогтвортой хөгжлийн 17 зорилтод Монгол Улс хэрхэн хүрэх, гарч буй ахиц явцаа хэрхэн хянаж, үнэлэх асуудлыг хөндөж "Тогтвортой Хөгжлийн Зорилтууд 2030: Үндэсний Үнэлгээний Тогтолцоо" сэдвийн дор төр, хандивлагч, иргэний нийгмийн төлөөллийг цуглуулсан.

2017

## Байгууллагын чанарын бодлого, чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлсэн жил

Судалгааны үр нөлөөг нэмэгдүүлэх, нийгэмд эерэг үр дүнд бодитоор авчрах, улсдаа төдийгүй бус нутагтаа тэргүүлэх хараат бус байгууллага байх зорилгоо бид "Монголын туршлагад суурилсан мэдлэгийн төв болно" хэмээн томъёолж уг зорилгод хүрэх таван жилийн стратегийг боловсруулав. Энэ хүрээндээ байгууллагын дотоод мэдлэгийн менежментээ сайжруулах үүднээс технологийн шинэчлэл хийж, ISO9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн, өдөр тутмынхаа үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Үүнтэй зэрэгцэн, энэ оны дундуур нийгмийн сайн сайхан байдлыг судалдаг "Азийн Судалгааны Консерциум"-д гишүүнээр элсэн, сүүлийн таван жил хийсэн Монголын нийгмийн сайн сайхан байдлын барометр судалгааг дэлгэн танилцуулав байна.

## САЛБАРЫН ОНЦЛОХ ТӨСЛҮҮД

### УУЛ УУРХАЙ

IRIM Судалгааны Хүрээлэн нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд уул уурхайн олборлох салбартай холбоотой 20 гаруй судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хэлэлцүүлгийн төслийг хэрэгжүүлжээ. Энэ ажлын хүрээнд уул уурхайн салбарын засаглал болон нийгэм, эдийн засгийн нөлөөллийн асуудлыг судлахаас гадна үндэсний болон орон нутгийн хэмжээний хэлэлцүүлгийн төслүүдийг гүйцэтгэсэн. Уул уурхайн засаглалтай холбоотойгоор, гар аргаар алт олборлогчид болон жижиг уул уурхайн компаниудын зөрчил, сайн туршлага, уул уурхайн лицензийн мэдээллийн нээлттэй ил тод байдал зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлсэн. Мөн уул уурхайн салбарт хэрэгжиж буй байгаль орчны хууль тогтоомж дахь “эрх зүйт ёсны зарчим”-ын үнэлгээ, уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээ, орон нутгийн хөгжилд бичил уурхайгаас оруулж буй хөрөнгө оруулалт, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны үнэлгээ зэрэг үнэлгээний төслүүдийг хэрэгжүүлжээ. Түүнчлэн үндэсний болон орон нутгийн түвшний олон талыг хамарсан бодлогыг боловсруулах, чадавхи бэхжүүлэх, салбарын асуудал тодорхойлох томоохон хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад байна. Уул уурхайн салбарын хүрээнд хэрэгжүүлсэн онцлог төслүүдийг дурдвал:

- **Ус ба уул уурхай: Олон нийтийн ойлголтын талаарх судалгаа. 2013–2015 он**

Энэ сэдэв нь сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн анхаарлын төвд байгаа, оролцогч талуудын хооронд маргаан үүсгэж буй гол сэдэв. Мөн энэ чиглэлээр бодлогын хүрээнд шийдвэр гаргахад хангалттай үндэслэл бүхий найдвартай мэдээлэл байхгүй. Энэхүү судалгаа нь усны нөөц, чанарт нөлөөлж буй уул уурхайн үйл ажиллагааны талаар авч үзэн бүх оролцогч талуудын байр суурийг тусгасан, мэдээллийн хэрэгцээг хангахуйц чухал ач холбогдолтой судалгаа болсон. Судалгааны үр дүнд үндэслэн бүх оролцогч талыг нэгтгэсэн дугуй ширээний уулзалт зохион байгуулж, усны менежментийн стратегийг боловсрууллаа.

- **“Орон нутагтай хамтран ажиллах загвар гэрээ” үндэсний хэлэлцүүлэг. 2015 он**

Орон нутагтай хамтран ажиллах загвар гэрээн дээр оролцогч талууд буюу уул уурхайн компани, Уул Уурхайн Яам, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагуудын санал, бодлыг нэгтгэх замаар гурван талт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн оролцогч талуудыг 6 чиглэлд хуваан хамтын ажиллагааны гэрээнд тэдний санал бодлыг тусган санал, зөвлөмж боловсруулан захиалагч талд хүргүүлсэн.

- **Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэлийн үнэлгээ. 2015–2016 он**

Авлигын эрсдэлийн үнэлгээг хийхдээ НҮБХХ-өөс боловсруулсан “Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бууруулах” олон улсын аргачлалыг ашигласан. Үнэлгээний хүрээнд нийт 15 төрлийн авлигын эрсдэл илрүүлэв. Үнэлгээний баг УУЯ-ны сайдын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны А/40 тоот тушаалаар батлагдсан “Уул уурхайн салбарын авлигын эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсэгт орж, авлигын эрсдэлийн үр дүнг танилцуулж, төлөвлөгөөнд саналаа тусгасан.

### БОЛОВСРОЛ

Монгол Улсын иргэн бүр бүх нийтээр боловсрол эзэмших боломжтой боловч шилжин суурьшигчид, малчид, эмзэг бүлгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дунд болон дээд боловсрол эзэмших бололцоо хязгаарлагдмал хэвээр байна. IRIM Судалгааны Хүрээлэн нь дунд болон дээд боловсролын чанар хүртээмжийг сайжруулах, нийгмийн эмзэг бүлгүүдийн боловсролын хэрэгцээ, чанар, хүртээмжийн чиглэлээр олон төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Салбарын онцлог төслүүдээс дурдвал:



- **“Хөгжлийн бэрхшээл ба боловсрол” 2014-2015 он**

Энэ судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар хийгдсэн үндэсний хэмжээнд төлөөлөхүйц цөөн судалгааны нэг юм. Судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын өнөөгийн байдал, боловсролын тогтолцооны олон хэлбэрийн талаарх оролцогч талуудын санал бодол, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг сургахад тулгарч буй бэрхшээл, шийдлүүдийг тодорхойлсон.

- **“Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийн суурь судалгаа болон эцсийн үнэлгээ. 2015-2018**

Судалгааны хүрээнд нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварын талаар багш, эцэг эх, оролцогч талуудын мэдлэг, ойлголт, оролцоо болон сургуулийн бүтэц тогтолцоог үнэлсэн. Суурь судалгааны үр дүнд үндэслэн “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийн үйл ажиллагааг төлөвлөж, нотолгоонд суурилсан төсөл хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулав.

- **“Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах нь” зөвлөх үйлчилгээ. 2015-2018.**

Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд, IRIM Судалгааны Хүрээлэн нь төгсөгчдийг мөшгөх улирал тутмын судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн жил тутмын судалгааг төлөвлөх, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, шаардлагатай тайланг бэлтгэхэд нь дээд боловсролын сургалтын байгууллагууд болон БСШУСЯ-ыг дэмжиж, техникийн туслалцаа үзүүлсэн. Бэлэн болсон тайланг дээд боловсролын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг шинэчлэх, ажил мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр оюутнуудыг хангах, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үйлдвэрлэлийн сургалтын хөтөлбөр болон хамтарсан судалгааны төслийг боловсруулахад ашиглана.

## ЗАСАГЛАЛ

Бид төрийн үйл ажиллагааны зохистой тогтолцоо, хууль тогтоомж, хяналтын механизмууд болон төрийн үйлчилгээний шударга, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад анхааран ажиллаж байна. Энэ чиглэлийн судалгаа, үнэлгээний ажлыг бид өмнөх судалгааны туршлага дээр суурилан, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, бодлого боловсруулагчид, холбогдох талуудын оролцоог хангах замаар гүйцэтгэж ирлээ. Засаглалын төслүүд нь бидний хэрэгжүүлсэн төсөл судалгааны 50 гаруй хувийг бүрдүүлж байна. Салбарын онцлог төслүүдээс дурдвал:

- **Шилэн түрийвч. 2009-2010 он**

Нээлттэй Нийгэм форумын захиалгаар төсвийн ил тод байдлын асуудлаар орон нутгийн засаглалын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн “Шилэн түрийвч” төслийг хэрэгжүүлсэн. Энэ төслийн хүрээнд орон нутгийн төрийн байгууллагын удирдлага дахь төсвийн ил тод байдлыг сайжруулах, дэмжлэг үзүүлэх сургалт, удирдамжийг өгсөн юм. Мөн төсвийн үйл явцад оролцох арга замуудыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад заасан. Энэ судалгааны ажил нь 2014 онд “Шилэн дансны тухай хууль” батлагдахад нөлөө үзүүлсэн.

- **Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал. 2009 оноос хойш**

Анх 2009 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн захиалгаар төрийн байгууллагуудын цахим хуудас нь ил тод байдлын шаардлагыг хангаж байгаа эсэх үнэлгээг IRIM Судалгааны Хүрээлэн гүйцэтгэсэн. “Шилэн дансны тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ууд батлагдсантай холбоотойгоор 2014 оноос хойш энэ үнэлгээг манай байгууллага жил бүр гүйцэтгэж байна. Эдгээр ажлын үр дүнд төрийн байгууллагын цахим хуудасны өөрчлөлтийн талаарх мэдээллийн бааз бий болсон.

- **Зөвлөх үйлчилгээ. 2017 он**

Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор шинэчлэн батласан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг

журам"-ын дагуу төрийн байгууллагуудын төлөвлөлт, хяналтыг сайжруулах хэд хэдэн зөвлөх үйлчилгээг IRIM Судалгааны Хүрээлэнгийн зөвлөхүүд хэрэгжүүллээ. Энэ хүрээнд Европын Холбооны "Үр дүнд суурилсан нэгдсэн менежмент" төслөөр дамжуулан Сангийн Яамны мэргэжилтнүүдэд дээрх журмын зүйл, заалтуудад нийцүүлсэн хөгжлийн төлөвлөлт, хяналтыг сайжруулах зөвлөх үйлчилгээг үзүүллээ. Мөн Дэлхийн Банктай хамтран "Хэрэглэгчийн үнэлгээ"-г зохион байгуулах ерөнхий удирдамжийг боловсруулан ЗГХЭГ-ын тушаалаар батлуулсан.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ажил олгогчдын хэрэгцээ шаардлага, ажиллах хүчний ур чадварыг тодорхойлохын тулд хөрөнгө оруулалт, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт хэр нийцэж байгааг тогтмол судалж, харьцуулах шаардлагатай юм. Энэ чиглэлд манай хэрэгжүүлсэн ажлуудаас онцлон дурдвал:

- **"Хөдөлмөрийн тухай хууль"-ийн хэрэгжилтийн үнэлгээ. 2013 он**

"Хөдөлмөрийн тухай хууль"-ийн хэрэгжилтэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд үндэсний хэмжээнд үнэлгээ хийсэн. Судалгаанд албан болон албан бус секторт ажил эрхлэгчид, бүх салбарын ажил олгогчдын төлөөллийг хамруулав. Энэ судалгааны үр дүнд нийт ажиллах хүчинд тулгарч буй асуудлаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, ахмад настан зэрэг нийгмийн бүлгүүдэд тулгарч байгаа асуудлуудыг тодорхойлсон. Судалгааны үр дүнд Засгийн Газар нь "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, батлууллаа.

- **Хөдөлмөр эрхлэлтийн барометрийн судалгаа. 2015 он**

Энэ судалгаа нь олон улсын аргачлалын дагуу ирэх нэг жилийн хугацаан дахь хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох зорилготой хийгдсэн. Судалгаанд 21 аймаг, 9 дүүрэгт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудаас түүвэрлэн 2050 аж ахуй нэгжийг хамруулан мэдээлэл цуглуулж 2016 оны ажиллах хүчний эрэлт хэрэгцээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, бүс нутгийн байршил болон ажил. мэргэжлийн бүлгээр тодорхойлон гаргасан.

## ЖЕНДЕР

IRIM Судалгааны Хүрээлэн нь үүсгэн байгуулагдсанаас хойш жендэрийн тэгш эрхийг хангасан шийдвэр гаргалтад шаардлагатай судалгаа, баримт нотолгоог бүрдүүлэх, бүх үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлын зарчмыг баримтлан ажиллахыг эрмэлзэж ирсэн. Хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, судалгааны ажлууддаа жендэрийн асуудлаар нотолгоонд суурилсан бодит, хараат бус мэдээллийг цуглуулж холбогдох хууль, эрх зүй, бодлогын баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах чиглэлд өөрсдийн хувь нэмрээ оруулсаар байна. Ингэснээр бид 2017 онд Жендэрийн Үндэсний Хорооны албан ёсны гишүүн болсон билээ. Энэ хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, судалгааг дурдвал:

- **"Төр засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд сонгогдох боломж" сонгогчдын хандлагын судалгаа. 2008 он**

Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурийн талаарх олон нийтийн санал бодол, түүнд нөлөөлж буй нийгэм сэтгэл зүй хүчин зүйлс, сөрөг хандлагыг даван туулахад эмэгтэй улс төрчдөд шаардагдах имидж, олон нийттэй харилцах бодлогын үндсэн чиглэлүүдийг тодорхойлсон.

- **"Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн индикатор" судалгаа, нөлөөллийн төсөл. 2010-2012 он.**

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн жендэрийн мэдрэмжийн талаар олон улсын туршлагыг судалж, монголын жендэр судлаачид, эмэгтэйчүүдийн хүний эрхийн экспертүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын оролцоон дээр суурилан "Хэвлэл мэдээллийн хэрэгслийн жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт"-ийг боловсруулсан.

- **“Монгол улс дах жендэрийн эрх тэгш байдал, олон нийтийн хандлага” туршилтын судалгаа. 2013 он.**

Соёл хоорондын туршилтын судалгаа (нэг удаагийн) нь жендэрийн тэгш байдалд анхаарал хандуулан шашин шүтлэг, нийгэм-эдийн засгийн байдал, хүйс болон бусад хүчин зүйлс нь нийгмийн тэгш байдлын хандлагатай хэрхэн уялдаж байгааг тодруулан судалсан.

- **Байгаль орчны салбарын жендэрийн үнэлгээ. 2017 он**

Судалгааны хүрээнд байгаль орчны салбарын жендэрийн стратегийн 1 дүгээр шатны хэрэгжилтэнд үнэлгээг хийж, жендэрийн тэгш байдлыг ойн салбарын жишээн дээр авч судалсан. Байгаль орчны салбарын жендэрийн стратегийн 1 дүгээр шатны хэрэгжилтийн хүрээнд гарсан ахиц, ололт амжилт, саад бэрхшээлийг тодорхойлж, стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан дараагийн шатны хэрэгжилтэнд санал, зөвлөмж боловсруулсан. Ойн салбар дахь жендэрийн тэгш байдлын өнөөгийн байдлыг судлан байгаль орчны салбарын үйл ажиллагаа, шийдвэр гаргалтанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах, баялагаас тэгш хүртэхэд шаардлагатай бодлого, шийдвэрийг боловсруулсан нь энэ салбарын хууль эрх зүйн орчныг сайржуулахад шаардлагатай баримт нотолгоо болох юм.

## **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ**

Монгол улсын нийт хүн амын 4 орчим хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ) эзэлдэг ба тэдний цөөн хувь нь боловсролд хамрагдаж, хөдөлмөр эрхэлж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцож байна. Манай оронд хөгжлийн бэрхшээлийн талаар нэгдмэл ойлголт, нэр томъёо байхгүй, салбар хоорондын бүртгэл, судалгаа зөрүүтэй, уялдаа муутай, энэ чиглэлийн хууль тогтоомжийн хэрэгжилт сул, бодлого хөтөлбөрүүд үр нөлөө муу байна. IRIM Судалгааны Хүрээлэн ХБИ-дэд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх, нийгмийн үйл ажиллагаанд тэгш, хүртээмжтэй оролцоход нь өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор дараах төслүүдийг хэрэгжүүлээд байна. Үүнд:

- **ХБИ-ийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого хөтөлбөрийн үнэлгээ. 2016 он**

Хөдөлмөрийн Яамны захиалгаар гүйцэтгэсэн тус төслийн хүрээнд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэх боломж, бэрхшээлийг судалж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмжийг боловсруулж холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлсэн.

- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй. 2016–2017 он**

Төслийг ДЗМОУБ-тай хамтран хэрэгжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, боловсролд тэгш хамруулах үйл ажиллагаа болон хүүхдийн бэрхшээлийг ЕБС-д түвшинд илрүүлэх, таних аргачлалыг боловсруулан туршив.

## IRIM-ИЙН 2017 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

IRIM Судалгааны Хүрээлэн үйл ажиллагаагаа өргөтгөн, шинэ оффисдоо үйл ажиллагаа явуулж эхлэв.

1 сар

Монголын үнэлгээний сүлжээг санаачилж үүсгэн байгуулав.

2 сар

"АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, нутагшуулах нь" үндэсний зөвлөлдөх уулзалтыг Монгол, Малайз, Вьетнам, Лаосын үнэлгээний холбоодтой хамтран зохион байгуулж, үүний үр дүнд МУ-д тохирох хөгжлийн бодлого, хөтөлбөрийн үнэлгээний хэм хэмжээг боловсруулав.

3 сар

Африкийн үнэлгээний холбооны Олон улсын 8-р хуралд гүйцэтгэх захирал А.Долгион оролцов. Уг хурлын үеэр Өмнөд-Өмнөдийн үнэлгээний хамтын ажиллагааны санаачилгыг эхлүүлэв.

4 сар

Ази-Номхон далайн үнэлгээний холбооны ТУЗ-ийн гишүүнээр сонгогдов.

5 сар

Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 5 аймгийн 99 суманд гүйцэтгэв.

6 сар

'21-р зууны ардчилал: Сорилтууд ба цаашдын хандлага' сэдэвт Олон улсын бага хурлыг зохион байгуулах эрхийг албан ёсоор авав.

7 сар

НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр "Нийгмийн халамжийн зардлын өөрчлөлт, төсвийн бууралтын нөлөөний шууд мониторинг" төсөл хэрэгжиж эхлэв.

8 сар

Австралийн Засгийн газрын тэтгэлэгт шалгарч "Судалгаа ба оролцоог хангах замаар Монголын Уул уурхайн салбарт үр дүнтэй засаглалыг бэхжүүлэх" чадавхи бэхжүүлэх хөтөлбөрийг Австралийн Гриффитийн Их сургуультай хамтран хэрэгжүүллээ.

9 сар

Зүүн Өмнөд Азийн 'Субъектив сайн сайхан байдлын олон улсын консорциум'-ийн гишүүнээр элсэв.

10 сар

ОУ-ын валютын сан/ Дэлхийн банкны хуралдаанд захирал Ц.Батсугар оролцов.

- Япон улсын Социологийн Нийгэмлэгийн 90 дэхь хуралд IRIM ТУЗ-ийн гишүүн Л.Цэлмэгсайхан оролцов.

11 сар

- IRIM ТУЗ-ийн гишүүн Я.Бямбасүрэн Токио хотод International Trust Conference-ийн хуралд оролцож, Монголын нийгэм дэх итгэлцэл сэдвээр илтгэл тавив.

12 сар

IRIM-Жилийн хүлээн авалт 2017 уламжлалт арга хэмжээг "Төлөвлөлт ба хяналт-шинжилгээ, үнэлгээний уялдаа: Бодлогын үр дүн, өгөөжийг нэмэгдүүлэх арга зам" сэдвийн дор зохион байгуулав.


### АФРИКИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОЛБООНЫ ОЛОН УЛСЫН 8 ДУГААР ХУРАЛД ОРОЛЦОВ.



Африкийн Үнэлгээний Холбоо нь 1999 онд байгуулагдсан дэлхийн хамгийн анхны бүс нутгийн үнэлгээний холбооны нэг бөгөөд энэ жил тус холбооны Олон Улсын 8 дугаар хурал Угандагийн Кампала хотод зохион байгуулагдлаа. Хуралд Африкийн Үнэлгээний Холбоо, Ази Номхон Далайн Үнэлгээний Холбоо, Латин Америк болон Өмнөд Азийн Үнэлгээний Холбооны төлөөллүүд оролцсон бөгөөд “соёлын онцлогт нийцсэн” үнэлгээг хэрхэн хөгжүүлэх талаар хэлэлцлээ. Соёлын онцлогт нийцсэн үнэлгээ нь сүүлийн арваад жилд Африк тивд эрчимтэй яригдаж байна. Үүнтэй холбоотой

хийгдсэн судалгаа, санаачилгууд нь “Африкт үйлдвэрлэв” буюу “Evaluation Made in Africa” нэртэйгээр олонд танигдаж эхлээд байна. Энэ санаачилга нь Монголд хийгдэж байгаа болон цаашид хийгдэх үнэлгээг шат ахиулахад ач холбогдолтой, санаа авах ёстой санаачилга юм. Монголын Үнэлгээний Сүлжээ нь цаашид Ази Номхон Далайн Үнэлгээний Холбоо болон бусад бүс нутгийн үнэлгээний холбоодтой хамтарч, өөрсдийн хувь нэмрээ оруулан ажиллах болно.

### IRIM Судалгааны Хүрээлэн АВСТРАЛИЙН ГРИФФИТИЙН ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ



IRIM Судалгааны Хүрээлэн нь нийгмийн олон салбарт ажиллаж байгаагийн нэг нь уул уурхай болон байгаль орчны засаглал, тогтвортой хөгжлийн асуудал билээ. Энэ хүрээнд Австралийн Гриффитийн их сургуультай (Griffith University) хамтран Австралийн Засгийн Газрын тэтгэлэгт шалгарч “Судалгаа ба оролцоог хангах замаар Монголын уул уурхайн салбарт үр дүнтэй засаглалыг бэхжүүлэх” чадавхи бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн гол зорилго нь тогтвортой хөгжилд чиглэсэн Австралийн сайн туршлагыг судлах замаар уул уурхайн салбарын сайн засаглалыг бэхжүүлж,

Монгол улсын уул уурхайн салбараас хүртэх ашгийг нэмэгдүүлэх зорилготой юм. Хамтарсан тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд оролцоог хангасан эдийн засгийн өсөлт, хувийн хэвшлийн засаглал, уул уурхайн салбарын ил тод байдлыг сайжруулах чиглэлээр хамтарсан судалгааг хэрэгжүүлэх замаар зочин судлаачдад энэ салбарт мэргэшэх боломжийг олгосон.

Хөтөлбөрийн хүрээнд зочин судлаачид болох Ц.Батсугар, Н.Минжирмаа, Т.Элбэрэл нар Уул уурхайн засаглалын чиглэлээр судалгааны үр чадвараа дээшлүүлж, хөтөлбөрөөс олж авсан мэдлэг, туршлагаа хуваалцан, судалгааны үр дүн, эрдэм шинжилгээний өгүүлээ Монголын уул уурхайн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, уул уурхайн салбарын мэргэжилтнүүдэд танилцуулж, хэлэлцүүлээ. Уг хэлэлцүүлэгт Австралийн Гриффит их сургуулийн хөтөлбөрийн удирдагч доктор Тапан Саркер хүрэлцэн ирж оролцов.

IRIM Судалгааны Хүрээлэн нь уул уурхайн салбарт сайн засаглалыг хөгжүүлэхийн тулд, уул уурхайн салбарын судалгаа, дүн шинжилгээ хийж Монгол Улсад тогтвортой уул уурхайн үндэсний сүлжээ бий болоход хувь нэмрээ оруулах болно.

## “НИЙМИЙН САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГААНЫ ОЛОН УЛСЫН ТҮНШЛЭЛ”-ИЙН ГИШҮҮНЭЭР ЭЛСЭВ



IRIM Судалгааны Хүрээлэн нь 2016 оноос “Субъектив сайн сайхан байдлын судалгаа”-г санаачлан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2017 оны 10 дугаар сард “Ази дахь Нийгмийн сайн сайхан байдлын судалгааны консорциум”-д Монгол Улсыг төлөөлж гишүүнээр элсэв. Энэ бүс нутгийн хамтарсан судалгааны төслийг 2014 онд Японы Засгийн Газрын хувийн их сургуулиудын “Стратеги судалгааг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Японы Сеншү их сургуулийн Нийгмийн Сайн Сайхан Байдлын Судалгааны Төв санаачлан эхлүүлсэн. Судалгааны төсөл нь Ази дахь нийгмийн сайн сайхан байдлын төлөв байдлыг

судлах, энэ чиглэлээр ажилладаг эрдэм шинжилгээний байгууллага, институтээс бүрдсэн олон улсын судалгааны консорциумыг байгуулах зорилготой. Консорциумд Монгол, Япон, Вьетнам, Тайланд, Солонгос, Тайвань, Филиппин, Индонезийн их сургууль, судалгааны байгууллагууд гишүүнээр элсэж хамтарсан судалгааг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд IRIM Судалгааны Хүрээлэн нь (1) субъектив сайн сайхан байдал, нийгмийн нийцлийн талаарх судалгааны үр дүнгээ Азийн бусад орны судалгаатай харьцуулах (2) Олон улсын хурал зохион байгуулах, оролцох, судалгааны үр дүнг үндэсний болон бүс нутгийн бодлого боловсруулагчдад түгээх, (3) мэргэжлийн сэтгүүлд үр дүнгээ нийтлэх боломжтой болж байна. Улмаар бид Монгол Улс дахь нийгмийн суурь судалгааны үр дүнг олон улсын тавцанд бүс нутгийн шилдэг судлаач, эрдэмтэд, бодлого боловсруулагчидтай хуваалцах, өөрийн орны нийгмийн нөхцөл байдал аль түвшинд явааг харьцуулах үүд хаалгыг нээсэн билээ.

## IRIM- ЖИЛИЙН ХҮЛЭЭН АВАЛТ-2017 АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Манай байгууллага 2015 оноос эхлэн “Жилийн хүлээн авалт”-ыг зохион байгуулж байгаа бөгөөд жил бүр тодорхой нэг сэдэвт анхаарлаа хандуулж, тухайн асуудалд талуудын ойлголт, оролцоог нэмэгдүүлэхийг зорьдог билээ. 2017 оны хүлээн авалтыг “Төлөвлөлт ба хяналт шинжилгээ, үнэлгээний уялдаа: Бодлогын үр дүн, өгөөжийг нэмэгдүүлэх арга зам” сэдвийн дор зохион байгууллаа. Энэ агуулгын хүрээнд төлөвлөлт, үнэлгээ хоорондоо уялдаагүй байгааг нэгдмэл болгох, төлөвлөлт, үнэлгээний үйл явцад иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, үндэсний эрх ашгийг эн

тэргүүнд тавьж хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай байгааг оролцогчдод уриалав.

## IRIM-ИЙН САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

### МОНГОЛЫН НИЙГМИЙН НЯГТРАЛ, СУБЪЕКТИВ САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА



#### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM Судалгааны Хүрээлэн

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Монголчуудын субъектив сайн сайхан байдлыг үнэлгээний шинжлэх ухааны арга аргачлалаар цуглуулсан баримт нотолгоог цаг хугацаа, орон зайн тархалттай бий болгох

Зорилт:

- Сайн сайхан байдлыг илүү нарийн хэмжих
- Олон салбарын мэдээллийг харьцуулж, гүйцэтгэлд нарийн шинжилгээ хийх
- Баримт, нотолгоонд суурилсан бодлогыг бэхжүүлэх
- Нийгмийн ахиц дэвшилд хөтөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх
- Нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх илүү сайн стратегийг боловсруулах
- Нийгмийн сайн сайхан болон ахиц дэвшлийг хэмжих байдлыг сайжруулах
- Асуудлуудад харьцуулахуйц хандлагыг санал болгох




2016

6-р сар

2017

12-р сар

### ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Улаанбаатар хотод болон хөдөөгийн 12 аймаг (Архангай, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий)-ийг хамран судалгааны мэдээлэл цуглуулаад байна.*

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Субъектив сайн сайхан болон аз жаргалын үнэлгээ нь амьдралын чанарыг хэмжих гол үзүүлэлтүүдийн нэг хэдий ч саяхныг хүртэл түүнийг хэмжих боломжгүй гэж үзэж байв. Харин сүүлийн хорин жилд судалгаа, шинжилгээний байгууллагуудын чармайлтын үр дүнд субъектив сайн сайхныг хэмжих, үнэлэх боломжтой болсон. Субъектив сайн сайхны судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэх байдал нэмэгдэж байна. Тухайлбал, Галлап олон улсын судалгаа (the Gallup World Poll), Дэлхийх үнэ цэнийн судалгаа (World Values Survey), Европын

нийгмийн судалгаа (the European Social Survey), Евробарометр судалгаа (Eurobarometer), Латинобарометр (Latinobarometer), Азийн барометр (Asian Barometer), Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Амьдралын илүү сайн индексүүд (OECD Better Life Index).

Сайн сайхныг хэмжихэд дэлхий нийтээрээ ахиц гаргаж байгаа ч Монгол улсын хувьд субъектив сайн сайхан, нийгмийн нийцлийн талаар нарийвчилсан судалгааны, түүний үр дүнд хийсэн шинжилгээний ажил хомс хэвээрээ байна. Энэ хомс байдал нь иргэдийн нийгмийн талаарх бодит үнэлгээнд тулгуурлан төрийн бодлого, шийдвэр гаргах урьдач нөхцлийг бүдэгрүүлж байна. Энэ



хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзаж Хараат бус судалгааны хүрээлэн субъектив сайн сайхан, нийгмийн нийцлийн судалгаа хийж, мэдээллийн сан бий болгох санаачилгыг 2016 онд хэрэгжүүлж эхэлсэн. Судалгаа нь дараах чиглэлд мэдээлэл, баримт нотолгоог бий болгоно.

- **Хүмүүсийн** сайн сайхан байдлын талаарх үнэлгээний мэдээлэл
- **Хүн амын бүлгүүдийн** амьдралын дундаж нөхцлөөс гадна тэдний сайн сайхан байдал
- **Хүмүүсийн амьдралын нөхцлийн тэгш бус байдлын** хэмжигдэхүүн
- **Үр дүнгийн индикатороор** хэмжиглэх сайн сайхан байдлын ололт, амжилтууд
- **Хүмүүсийн сайн сайхны объектив болон субъектив талууд**

Нийгмийн нийцэл болон субъектив сайн сайхны судалгаа нь харьцуулагдахуйц түүвэртэй ба олон улсад харьцуулагдахуйц. Судалгааг байнгын нийцтэй, жилийн өөр өөр үеүдэд нийгмийн өөр өөр бүлгүүдийг хамруулж зохион байгуулна.

Судалгааны үр дүнг олон улсын судлаачид танилцуулах ажлын хүрээнд Австри, Япон, Вьетнам, Индонез, зэрэг улсад болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд танилцуулахаас гадна 2016 онд IRIM Азийн нийгмийн сайн сайхны судалгааны конзерциумын гишүүн болсон. Уг хөтөлбөрийн хүрээнд IRIM судалгааны хүрээлэн нь (1) субъектив сайн сайхан байдал, нийгмийн нийцлийн талаарх судалгааны үр дүнг Азийн бусад орны судалгаатай харьцуулах (2) Олон улсын хурал зохион байгуулах, оролцох, судалгааны үр дүнг үндэсний болон бүс нутгийн бодлого боловсруулагчдад түгээх, (3) Мэргэжлийн сэтгүүлд үр дүнгээ нийтлэх боломжтой болж байна.

Улмаар бид Монгол улс дахь нийгмийн суурь судалгааны үр дүнг олон улсын тавцанд бүс нутгийн судлаач, эрдэмтэд, бодлого боловсруулагчидтай хуваалцах, өөрийн орны нийгмийн нөхцөл байдал аль түвшинд явааг харьцуулах боломж нээгдээд байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны арга зүйг Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын 2013 оны

субъектив сайн сайхны судалгааны гарын авлагат тулгуурлан боловсруулсан. Судалгааны дизайнд **респондентийн хүн ам зүйн мэдээллүүд болон хүмүүсийн амьдралын чанар болон материаллаг нөхцөл байдалтай холбоотой олон хүчин зүйлсийн талаар асуултуудыг багтаасан нь нарийн шинжилгээ хийх боломжийг** бий болгож байна. Энэхүү асуумж нь 'сайн сайхны суурь судалгаа', 'амьдралын үнэлгээ', 'юдемоник буюу амьдралын утга учрын', 'амьдралын олон талт үнэлгээ', 'сэтгэл хөдлөлийн үнэлгээ' гэсэн таван хэсгээс бүрдэнэ.

Амьдралын үнэлгээ	Хүмүүс амьдралаа болон амьдралынхаа зарим талууддаа өгч буй үнэлгээ
Юдемоник буюу амьдралын утга учрын үнэлгээ	Хүмүүс амьдралын утга учир, зорилго, сэтгэл санааны байдалдаа өгч буй үнэлгээ
Сэтгэл хөдлөлийн үнэлгээ	Хүмүүсийн мэдрэмж буюу сэтгэл санааны байдалдаа өгч буй үнэлгээ, Ерөнхийдөө тодорхой нэг цаг хугацаанд үнэлэгдэнэ


2016-аас 2017 оны хооронд Улаанбаатар болон нийт 12 аймагт нийт 1825 судалгааны асуумжаар мэдээлэл цуглуулсан. Судалгаанд кластер болон шугаман огтлолцлын түүвэр<sup>1</sup>-ийг ашигласан. Мэдээлэл цуглуулалт нь тухайн жилд болсон Монголын томоохон үйл явдлуудтай давхацсан болон үл давхацсан цаг хугацааны хүрээнд хийсэн. Энэ нь үйл явдал, цаг үеийн байдал хүмүүсийн субъектив сайн сайхан байдлын үнэлгээнд нөлөөлж байгаа эсэхийг танин мэдэх боломжийг олгосон.

1. 2016 оны 06 сарын 09-өөс 2016 оны 06 сарын 20- Монгол улсын парламентийн сонгууль 2016 он (Зун)
2. 2016 оны 09 сарын 08-аас 2016 оны 09 сарын 15- Хичээлийн шинэ жилийн эхлэл
3. 2017 оны 02 сарын 01 – 2017 оны 02 сарын 12- Эрдэнэт үйлдвэрийн 49%-ийн хувьцаа (Өвөл)

<sup>1</sup> Хөдөө орон нутагт нэг зүгийг сонгоод, сонгосон зүгт тааралдсан респондентоос судалгаа авна

## ҮР ДҮНГҮҮД

Судалгааны үр дүнг дараах графикт хураангуйлав.



## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Дээрх зургуудад харуулснаар судалгааны үр дүнгээс харахад субъектив сайн сайхан байдал ба насны бүлгүүдийн хооронд хамаарал байна. Нас нэмэгдэхийн хэрээр субъектив сайн сайхан байдлын түвшин буурч байна.

Төрийн албан хаагчдын субъектив сайхны байдал хувийн байгууллагад ажилладаг хүмүүсийнхээс илүү өндөр байна. Респондентуудын амьдардаг газрын байршил нь субъектив сайн сайхны байдалд нөлөөлдөг үр дүн гарсан байна. Төв газарт буюу хотод амьдардаг хүмүүс, хөдөө орон нутагт амьдардаг хүмүүстэй харьцуулахад

субъектив сайн сайхны байдлаа илүү өндөр үнэлсэн байна. Оролцогчид улс орны эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалд сэтгэл ханамж хамгийн бага байгаагаа илэрхийлсэн бол өөрсдийн хувийн амьдрал болон өөрийн бүлгийн хамтын ажиллагаанд хамгийн их сэтгэл ханамжтай байдгаа илэрхийлжээ.

Үнэлгээний динамикийн гаргахын тулд бид судалгааг тасралтгүй, олон жилийн давтамжтайгаар зохион байгуулах шаардлагатай юм. Цаашид судалгааг IRIM судалгааны хүрээлэн үргэлжлүүлэн зохион байгуулах ба судалгааны үр дүнг бодлогын хэлэлцүүлэгт ашиглах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх анхаарч ажиллана.

## “АСЕАН БҮСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СТАНДАРТЫН ХҮРЭЭГ МОНГОЛД НЭВТРҮҮЛЖ, НУТАГШУУЛАХ” ТӨСӨЛ



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Евал Партнерс Интернейшнл

Олон улсын үнэлгээний хамтын ажиллагааны байгууллага

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, үнэлгээний чиглэлээр оролцогч талуудын үйл ажиллагааг дэмжих, Монголын үнэлгээний сүлжээг бий болгох юм.



# 2017

3-р сарын 17

# 2017

3-р сарын 22

ХАМРАХ ХҮРЭЭ

Төсөл Улаанбаатар хотод хэрэгжсэн.

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

АСЕАН-ы орнуудын Үнэлгээний стандартын ерөнхий хүрээг (АРФЭС) боловсруулах үйл ажиллагааг ЕвалПартнерс Интернейшнл (Eval Partners International) байгууллагаас санаачилж, Олон улсын үнэлгээний хамтын ажиллагааны байгууллага (IOCE)-ын хэрэгжүүлж буй Харилцан суралцах хөтөлбөрөөс (Peer-to-Peer) санхүүжүүлсэн юм. АРФЭС төслийг Малайзийн үнэлгээний холбоо (MES) удирдаж байгаа бөгөөд АСЕАН-ы бүсийн 3 байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Эдгээр байгууллагууд нь Камбожийн үнэлгээний холбоо (CamES), Вьетнамын хяналт-шинжилгээ, үнэлгээний сүлжээ (VNME) болон Индонезийн хөгжлийн үнэлгээний холбоо (InDEC) багтаж байна. Энэхүү үйл ажиллагаанд оролцож буй тав дахь түншлэгч байгууллага нь Малайзын Шинжлэх ухаан, технологийн их сургууль бөгөөд хувийн хэвшлийн их сургуулиудаас анх удаа Үнэлгээний чиглэлээрх мэдээллийн төвийг байгуулан, Үнэлгээ болон үнэлгээг хийх талаар онолын болон мэргэжил арга зүйн сургалтыг явуулж байна.

АСЕАН бүсийн хөгжиж буй орнуудын олонхи нь үндэсний хэмжээний үнэлгээний стандартгүй, ийм баримт бичиг боловсруулах зайлшгүй шаардлага тулгарч байгаа зэргээс үүдэн АРФЭС баримт бичгийг боловсруулах санаа гарсан юм. Нэг талаас хөгжиж буй болон буурай эдийн засагтай улс орнуудын аль алинд нь дунд болон урт хугацааг хамарсан үнэлгээ хийлгэх хэрэгцээ нэмэгдэж байгаа боловч, нийлүүлэлт талаас мэргэжлийн үнэлгээ хийх туршлага сул, тодорхой стандарт байхгүй байгаа нь ихээхэн бэрхшээлийг учруулж байна. АСЕАН-ы гишүүн 10 улсын 6 нь буюу Камбож, Индонез, Малайз, Филиппин, Тайланд болон Вьетнамд үндэсний хэмжээний, сайн дурын мэргэжлийн үнэлгээний байгууллагатай байна. Хамгийн тодорхой анзаарагдаж байгаа сул тал нь АСЕАН-ын гишүүн орнуудын алинд ч үнэлгээний үндэсний стандарт/журам байхгүй байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Төслийн хүрээнд Монгол улсад үнэлгээний чиглэлээр ажилладаг шийдвэр гаргах түвшний төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, судлаач нарын дунд АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, нутагшуулах төслийн хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан.

Оролцогч талууд:

- Монголын үнэлгээний сүлжээний гишүүн, зөвлөхүүд
- Засгийн газрын төлөөлөгчид
- Төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид
- Байгууллагууд болон Их сургуулиудын төлөөлөгчид
- Үнэлгээний чиглэлээр бие даан ажилладаг зөвлөхүүд


## ҮР ДҮН:

АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, нутагшуулах төслийн хэлэлцүүлэг уулзалтын хүрээнд АРФЭС баримт бичгийн бүлэг тус бүр дээр хэлэлцэж оролцогч талуудын саналыг авсан.

Зөвлөлдөх уулзалтанд оролцсон оролцогч талуудад өгсөн санал зөвлөмж:

- Монголын үнэлгээний сүлжээг өргөжүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон, төрийн бус байгууллага, хувь судлаачидын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- Хэлэлцүүлгийн явцад гарсан (АРФЭС) баримт бичигтэй холбоотой саналуудыг хэлэлцэж (АРФЭС) баримт бичгийг батлах
- Монголын үнэлгээний сүлжээний орчинг боловсронгуй болгох

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM Судалгааны Хүрээлэн

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэ судалгаа нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн дагуу төрийн байгууллагуудын веб сайтад мониторинг хийн хуулийн хэрэгжилтийг холбогдох үзүүлэлтүүдээр үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Судалгаанд 2011 онд боловсруулсан 5 үзүүлэлт бүхий мониторингийн судалгааны арга зүйг зарчмын хувьд баримтлан ажилласан ба энэ нь судалгааны үр дүнг жил бүр харьцуулахуйц байдлыг бий болгох юм. Мөн төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал зэрэг 4 үзүүлэлтээр үнэлэх
- Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг “Шилэн дансны тухай хууль”-ийн заалтуудыг баримтлан хэрэгжилтийг үнэлэх
- Мониторингийн үр дүнг өмнөх жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэх
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.



# 2017

8-р сар

# 2017

12-р сар

## СУДАЛГААНЫ ХҮРЭЭ

Судалгааны хүрээнд төрийн 81 байгууллагын цахим хуудсанд үнэлгээ хийн мэдээллийг цуглуулан ажиллаа. Үүнд:

- Монгол Улсын Яам -13;
- Монгол Уулсын Хэрэгжүүлэгч Агентлаг -17;
- Монгол Улсын Тохируулагч Агентлаг -10;
- Монгол Улсын Орон Нутгийн Захиргаа - 21;
- Нийслэл, Дүүргийн захиргаа - 11
- Улсын Их Хурал болон түүний харьяа байгууллага -9

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Сайн засаглалын үндсэн элементийн нэг нь ил тод байдал юм. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангах мэдээллийн гол эх сурвалж бол тухайн байгууллагын цахим хуудас байдаг. Энэ ил тод байдлыг сайжруулахын тулд Засгийн Газраас Монгол Улсын үндсэн хуулийн арван зургаадугаар зүйл, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр, “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль”, Засгийн Газрын 143 дугаар тогтоол зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлж байна. IRIM Судалгааны Хүрээлэнгээс жил бүр төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдлын төвшинг үнэлэх мониторингийн судалгааг тасралтгүй хийж байна.


## ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Судалгааны төсөл нь дараах 3-н үе шатын дагуу хэрэгжсэн. Үүнд:

1. Цахим хуудсуудад шалгуур үзүүлэлтээр хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгааг үнэлэх
2. 2011 оноос хойш хийгдсэн бүх судалгааг харьцуулагдахуйц байдлаар үзүүлэлтүүдийг харуулах
3. Төрийн байгууллагуудыг эрэмбэлэх

Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүдийн аль нь ил тод байдлыг илтгэхэд илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ? гэдгийг ялгаатай байдлаар тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлыг дүрс 1-д харуулав.


Дүрс. 1 Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээний системд эхлэх хувь



## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Төрийн байгууллагын цахим хуудасны үнэлгээ 2011 оноос 2015 оныг хүртэл тасралтгүй өсөлттэй үр дүнг харуулж байсан ч 2016 оны үнэлгээгээр мэдэгдэхүйц буурсан байна. 2017 оны төрийн байгууллагын цахим хуудасны үнэлгээгээр өнгөрсөн оны үзүүлэлтээс 9.4 хувиар өссөн үзүүлэлт гарч байгаа ч “Зарим талаар ил тод” гэсэн ангилалд багтсан хэвээр байгаа юм.

Дүрс. 2 Төрийн байгууллагын цахим хуудсын үнэлгээ, оноор



Дэлгэрэнгүй шалгуур үзүүлэлт тус бүрээр нь харуулсан байгааг Дүрс 3-с харна уу.

Хүснэгт. 1 Төрийн байгууллагын цахим хуудасны үнэлгээ. /шалгуур үзүүлэлт тус бүрээр/

Шалгуур үзүүлэлт	2011	2014	2015	2016	2017
Хамааралтай байдал	30.2	40.8	56.4	49	58.1
Найдвартай байдал	9.2	13.9	47.1	55.8	55.1
Мэдээллийн цаг үеийн байдал	7.2	28.8	39.5	41.5	38.5
Мэдээллийн хүртээмжтэй байдал	44.9	37.8	44.7	37.2	60.2
Ашиглахад хялбар байдал	59.8	28.8	39.5	41.5	69.3

2017 онд хийгдсэн төрийн байгууллагын цахим хуудасны үнэлгээний үр дүнгээр “Мэдээллийн хүртээмжтэй байдал” нь хамгийн өндөр өсөлттэй гарсан байна. Дээрх хүснэгтээс харахад “Мэдээллийн цаг үеийн байдал” өмнөх оны үзүүлэлтээс гурван хувиар буурсан байгаа

нь “Зарим талаар ил тод” гэсэн ангилалаас “Хаалттай” гэсэн ангилалд шилжиж байгаа юм. Энэ нь төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа цаг тухайд нь мэдээлэх байдал суларсныг харуулж байна.


Дүрс. 3 Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал. 2017 он



Дүрс 3-аас харахад 2017 онд аймгуудын цахим хуудас өндөр үзүүлэлтэй буюу “Ил тод” ангилалд байгаа бол бусад төрийн байгууллагын дундаж “зарим талаар ил тод” ангилалд байна. Энэ нь 2016 оны сонгуулийн жилтэй холбоотойгоор Засгийн Газрын яамд болон агентлагууд бүтцийн хувьд шинэчлэгдэн, зарим төрийн байгууллагуудын цахим хуудас өөрчлөгдөх, хаагдах, нэг хэсэг нь шинээр нээгдсэн зэргээс шалтгаалж зарим

яамдууд, парламентийн харъяа байгууллагууд доогуур үнэлэгдэж байна. Үнэлгээний үр дүнгээс үзвэл орон нутгийн захиргааны байгууллагууд хамгийн өндөр үнэлэгдсэн ба УИХ-ын сонгуулийн үр дүн, Засгийн Газрын бүтцийн өөрчлөлт зэргээс хамаарч цахим хуудсанд өөрчлөлт орох нь бага байдаг нь бусад төрийн байгууллагаас өндөр үнэлэгдэхэд нөлөөлсөн байна.

Дүрс. 4 Мэдээллийн ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүд



Мэдээллийн ил тод байдлын тухай хуулинд туссан мэдээллийн ил тод байдлыг хангах дээрх дөрвөн хэмжих үзүүлэлтийн хэрэгжилтийг үнэлэх нь судалгааны зорилго байсан. Дөрвөн үзүүлэлт тус бүрээр гол үр дүнгүүдийг буулгаж байна.

- 2017 онд Үйл ажиллагааны ил тод байдал сайжирсан.
- Байгууллагуудын төсөв, санхүүгийн ил тод байдал нилээд сайжирсан буюу 2011 онд 41.1% байсан бол 2017 онд 70.6% болон өөрчлөгдсөн байна.
- Байгууллагуудын вэб сайт дахь хүний нөөцийн ил тод байдал сайжирсан.
- Худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал мөн адил өссөн байгаа

нь өгөгдсөн графикаас харагдаж байгаа ба 2011 онд 38.7% байсан бол 2017 онд 47.9% болон өөрчлөгдсөн байна.

Ерөнхийдөө төрийн байгууллагын төсөв санхүүгийн мэдээлэл ил тод байдал нь бусад үзүүлэлтээс илүү ил тод байгаа бол худалдан авах ажиллагааны ил тод байдал хамгийн бага хувьтай үнэлэгдсэн байна.

### ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Судалгааны үр дүнд үндэслэн төрийн байгууллагуудын цахим хуудсын ил тод байдлын чиглэлээр дараах давуу болон сул талууд ажиглагдаж байна.

#### Хүснэгт.2 Төрийн байгууллагын цахим хуудсын ил тод байдлын ололттой болон дутагдалтай тал

Ололттой талууд	Дутагдалтай талууд
“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-ийн хүрээнд төрийн байгууллагууд цахим хуудсандаа мэдээлэл оруулах байдал сайжирч байна.	Веб сайтад тавигдаж буй мэдээлэл нь ихэнхдээ найдваргүй, хуучирсан, мэдээллийн шинэчлэл муу байна.
Бүх төрийн байгууллага албан ёсны цахим хуудсаар дамжуулан хэрэглэгч, иргэдийг мэдээллээр хангах боломжтой болсон.	Мэдээллийн нэг талын урсгал давамгайлж байгаа бөгөөд иргэдийн санал хүсэлтийг авах, оролцоо хангах зэрэг эргэх холбоо дутагдалтай байна.
Вэб сайтууд нь техникийн энгийн шалгууруудыг хангаснаар төрийн байгууллагуудын вэб сайтын хандалт нэмэгдсэн.	Шинэ мэдээллийг тавихдаа зөвхөн техникийн талаас анхаарахаас төрийн байгууллагын салбар, хэлтэс, нэгжээс чанартай мэдээллийг тогтмол ханган нийлүүлэх тал дээр анхаарахгүй байна.
Шилэн дансны нэгдсэн цахим хуудас ажиллаж эхэлсэн ба төрийн байгууллагууд цахим хуудсандаа холбоос, линкийг байршуулж эхэлснээр төрийн худалдан авах ажиллагаа болон төсөв, санхүүгийн холбогдолтой мэдээллийн ил тод байдал сайжирч байна.	МУ-ын Засгийн Газар солигдсон тохиолдолд яамд болон агентлагуудын цахим хуудас өөрчлөгдөх, хаагдах, шинээр солигдох зэрэг асуудал үүсч байгаа нь мэдээллийн ил тод байдалд сөргөөр нөлөөлж байна. Шилэн дансанд мэдээллээ оруулсан тэмдэглэгээ харагдаж байгаа ч ороод үзвэл файлыг хавсаргаагүй, мэдээлэлгүй зэрэг дутагдалтай тал байсаар байна.



## ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ

World Vision  
Дэлхийн Зөн Монгол

IRIM  
INDEPENDENT  
RESEARCH  
INSTITUTE OF  
MONGOLIA



#### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Дэлхийн Зөн - Монгол Олон Улсын Байгууллага (ДЗМОУБ)

#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” (ХБХГИ) төслийн зорилго нь Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн (ХБХ) ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх явдал юм. Тус зорилгын хүрээнд дараах хоёр зорилтыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- ХБХ-ийг илрүүлэх үндэсний болон орон нутгийн стандарт, механизмийг сайжруулах
- ХБХ-ийг тохирох боловсролын үйлчилгээ, сургалтын хэрэгслээр хангаж хөгжүүлэхэд нь гэр бүл болон боловсролын байгууллагуудыг чадавхжуулах

Тус төслийг ДЗМОУБ-тай хамтран хэрэгжүүлсэн бөгөөд IRIM Судалгааны Хүрээлэн нэгдүгээр зорилтын хэрэгжилтийг хариуцан ажиллалаа.



# 2016

6-р сар

# 2017

9-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

БСШУЯ-ны мэдээгээр 2014–2015 оны хичээлийн жилд бага, дунд сургуульд нийт 505,816 суралцагч суралцаж байгаа ба нийт суралцагчдын хоёр хувийг (11,072) ХБХ эзэлж байна. Улсын хэмжээнд болон хөдөө орон нутагт сургууль завсардаж буй хүүхдүүдийн дийлэнх хувийг ХБХ бүрдүүлж байгаа ба үүнд сургалтын орчин, нөхцөл бүрдээгүй, багш мэргэжилтнүүдийн хүрэлцээгүй байдал голлон нөлөөлж байна. Мөн оны мэдээгээр нийт сургуулийн насны ХБХ-ийн 30 гаруй хувь нь (4,779) ямар нэг боловсролын үйлчилгээ авч чадалгүй сургуулийн гадна үлдсэн байна. Манай улсад өнөөдөр хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох нэгдмэл ойлголт, аргачлал дутмаг байгаагаас боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбаруудын тоо, статистик бүртгэл хоорондоо ихээхэн зөрүүтэй байна.

2014 онд Хараат Бус Судалгааны Хүрээлэн Японы Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Судалгааны Институтын (JICARI) захиалгаар үндэсний хэмжээнд гүйцэтгэсэн “Хөгжлийн бэрхшээл ба боловсрол” судалгааны үр дүнгээс үзвэл улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл ихээхэн зөрүүтэй, тодорхой бус гэсэн үр дүн гарсан юм. Мөн ЕБС-ийн түвшинд хүүхдийн бэрхшээлтэй эсэхийг ихэнх тохиолдолд багш нар өөрсдийн ажиглалт, хувийн туршлага дээр үндэслэн тодорхойлж байгаа бөгөөд нэгдсэн арга аргачлал, хэрэглэгдэхүүн байхгүй байна.

2014 онд Эрүүл Мэндийн Яам (ЭМЯ), БСШУЯ, Хөдөлмөр Нийгэм Хамгааллын Яамны (ХНХЯ)-ны гурван сайдын хамтарсан тушаалаар манай улсад хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох үүрэгтэй Эрүүл Мэнд, Боловсрол, Нийгэм Хамгааллын Төв болон салбар комисс (ЭМБНХК)-ыг аймаг орон нутаг, нийслэл дүүргийн түвшинд байгуулсан хэдий ч өнөөдрийг хүртэл тус комиссын үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй байна. Иргэдийн дунд ч энэ комиссын талаар хангалттай ойлголт мэдлэггүй байна. Иймд хүүхдэд тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийг эрт илрүүлж таних арга аргачлал

үндэсний хэмжээнд зайлшгүй шаардлагатай байгаа учраас Хараат Бус Судалгааны Хүрээлэн ХБХГИ төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд хүүхдийн бэрхшээлийг эрт илрүүлэх аргачлалыг нэвтрүүлэхээр ажилласан. Энэ аргачлал нь анхан шатны түвшинд /хороо, сургуулийн түвшинд/ хүүхдийн бэрхшээлийг илрүүлэх энгийн аргачлал бөгөөд албан ёсны оношилох эрх бүхий ЭМБНХК-ийн оношилгоонд орох шаардлагатай хүүхдүүдийг илрүүлэх боломжтой боллоо.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн баг хариуцаж буй нэгдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүллээ.

- **Суурь судалгаа.** Нийт 312 асуумж, 60 хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.
- **Бодлогын судалгаа.** Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгээс ХБХ-ийн чиглэлээрх заалт, журамд баримт бичгийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.
- **Олон улсын туршлага судлах судалгаа.** Австрали, Ирланд, Тайланд, АНУ тэгш хамруулах боловсролын системийн харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэсэн.
- **Ажлын хэсэг.** ХБХ-ийг анхан шатны түвшинд илрүүлэх аргачлалыг боловсруулж турших ажлыг холбогдох төрийн болон ТББ-ын төлөөллүүдээс бүрдсэн ажлын хэсэг хариуцан ажилласан
- **Илрүүлэх аргачлалын туршилт үнэлгээ.** Ерөнхий боловсролын 9 сургуулийн 500 хүүхдийн дунд туршилт үнэлгээ зохион байгуулсан.
- **Сургалт.** Нийт 120 гаруй өрхийн эмч, сургуулийн багш болон хорооны нийгмийн ажилтнуудад аргачлалыг ашиглах аргазүйг олгов.
- **Сайн туршлага шалгаруулах уралдаан болон богино хэмжээний нэвтрүүлэг.** Илрүүлэх аргачлалыг хэрэглээг

нэмэгдүүлэх зорилгоор ЕБС-иудын дунд уралдаан зарлав.

- **Байгууллагын чадавхи бэхжүүлэх сургалт болон зөвлөх үйлчилгээ.** ХБХ-д чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-ыг институцийн түвшинд чадавхжуулах сургалтыг зохион байгуулав.
- **Эцсийн үнэлгээ.** Зорилтот орон нутагт бий болгосон төслийн үр нөлөөг үнэлэх зорилгоор нийт 258 асуумж, 33 хагас бүтэцлэгдсэн ярилцлага, 9 фокус бүлгийн ярилцлага, 9 кейс судалгааг хийж гүйцэтгэлээ.

## ҮР ДҮНГҮҮД

Дээр дурдсан үйл ажиллагааны хэрэгжилтээс гарсан тойм үр дүнгээс дурдвал:

- **Суурь судалгаа:** Суурь судалгааны үр дүнд суурилан 2015–2016 онд ХБХ-ийн үнэлгээтэй холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн хороо, сургууль, дүүрэг байгаагүй. Салбар ЭМБНХК-ийн цөөн гишүүд ХБХ-ийг үнэлэх зарим аргуудыг мэдэж байсан ч яг хүүхдийг үнэлэхэд ашиглаж байгаа тохиолдол байхгүй байв.
- **Бодлогын судалгаа:** Судалгааны дүнгээр ХНХЯ-ны харьяа Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Хөгжлийн Хэлтэс нь сайдын дэргэдэх ХБИ-ийн Зөвлөлийн Ажлын Алба болж өөрчлөгдсөн ба салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах эрхтэй болсон хэдий ч яамдын ажлын уялдааг хангаж, нэгдсэн зохицуулалт хийхэд тус зөвлөлийн эрх мэдэл нь хүрэлцэхгүй байна. Мөн яамд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаанаас гадна төрийн болон ТББ, олон улсын байгууллага (ОУБ) хоорондын хамтын ажиллагаа, уялдаа ч сул байна.
- **Олон улсын туршлага судлах судалгаа:** Олон улсын нийтлэг туршлагаас үзвэл хүүхдийн хэрэгцээнд нийцүүлсэн боловсролын үйлчилгээг хүргэхэд сургууль болон тусгай боловсролын төвүүд (ТБТ)-ийн хоорондын хамтын ажиллагаа ихээхэн өндөр түвшинд байна. Сургууль дээр хүүхдийн бэрхшээлийг анхан

шатны түвшинд илрүүлэх үнэлгээний баг ажилладаг бөгөөд тус багийн үнэлгээгээр хүүхдэд дараагийн түвшний нарийн үнэлгээ шаардлагатай гэж үзвэл тухайн орон нутаг дахь ТБТ-дэд ханддаг байна.

- **Ажлын хэсэг:** Ажлын хэсгийн зүгээс Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сангийн (НҮБХС) боловсруулсан хүүхдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй аливаа эрсдлийг тодруулах зорилготой “Вашингтон бүлэг-Хүүхдийн үйл ажиллагаа” модулийг төслийн хүрээнд ашиглахаар сонгож, монгол хувилбарыг нь боловсруулан туршлаа.



### Илрүүлэх аргачлалын туршилт үнэлгээ:

Туршилт үнэлгээнд нийт ЕБС-ийн 500 суралцагч хамрагдсанаас 158 хүүхэд үйл ажиллагааны хувьд бэрхшээлтэй байгаа үр дүнг харуулсан. Үүнээс 87 хүүхэд нь нэгээс олон үйл ажиллагаандаа (харах, сонсох, алхах, суралцах, анхаарал төвлөрөх гэх мэт) бэрхшээлтэй байгаа нь илэрсэн байна.

- **Сайн туршлага шалгаруулах уралдаан болон богино хэмжээний нэвтрүүлэг:** ХБХ-ийг хөгжүүлэх чиглэлд сургуулиуд өөрсдийн санаачлагаар ажил хэрэгжүүлэх уралдаанд СХД-ийн 121-р сургууль нэгдүгээр байрыг, ЧД-ийн 17-р сургууль хоёрдугаар байр, БЗД-ийн 102-р сургууль гуравдугаар байрыг тус тус эзэллээ. Уралдаанд шалгарсан гурван сургуулийн хэрэгжүүлсэн санаачлагыг баримтжуулан богино хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд танилцуулаад байна.

- **Байгууллагын чадавх бэхжүүлэх сургалт болон зөвлөх үйлчилгээ:** Байгууллагын чадавхи бэхжүүлэх сургалтанд ХБХ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-ын 14 төлөөлөл хамрагдсан. Арга зүй олгох танхимын сургалтын дараа, сургалтанд хамрагдсан төслийн зорилтот байгууллагуудад үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой зөвлөх үйлчилгээг үзүүлсэн.
- **Эцсийн үнэлгээ:** Эцсийн үнэлгээний үр дүнгээр төсөлд хамрагдсан төрийн байгууллагуудын 67 хувь нь үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайландаа ХБХ болон хүүхдийн бэрхшээлийг эрт илрүүлэх аргачлалын чиглэлээр ажил тусгаж оруулсан нь үр дүнтэй байлаа. Төслийн хүрээнд зохион байгуулсан бусад үйл ажиллагаанд багш, эцэг эх, сурагч гэсэн гурван талыг хамруулсан нь хөгжлийн бэрхшээлийн талаар нэгдмэл ойлголт, мэдлэгтэй болоход эерэгээр нөлөөлсөн бөгөөд ХБХ-ийг дэмжих чиглэлд харилцах, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн юм.

## **ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ**

ХБХГИ төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө манай улсад хүүхдийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа эрсдэл бэрхшээлийг эрт илрүүлэх аргачлал байгаагүй. Ихэнх тохиолдолд багш нар өөрсдийн ажлын туршлага болон хувийн ажиглалт дээрээ үндэслэн хүүхдийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлдог байсан. Шинэ аргачлалыг нэвтрүүлснээр цаашид ЕБС-ийн багш ажилчдад хүүхдийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хүүхдийн талаар бодитой үндэслэлтэй мэдээлэл цуглуулахад арга зүйн хувьд томоохон дэмжлэг болсон гэж найдаж байна. ХБ-ыг илрүүлэх аргачлалыг хэрэглээнд нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрэх юм. Үүнд: Нэгдүгээрт, илрүүлэх аргачлалын хэрэглээ өргөн хүрээтэй нэвтэрснээр ХБХ-ийн бүртгэл статистик мэдээ тодорхой, үндэслэлтэй гарах боломж бүрдэнэ. Хоёрдугаарт, салбар ЭМБНХК-ийн оношилгоонд орох шаардлагатай хүүхдүүд тодорхой болох ба хүүхдийн бэрхшээлийг тодорхойлох үндэсний механизм сайжирна. Хамгийн гол үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй эсэх нь тодорхойлогдоогүй байсан хүүхдүүдийн бэрхшээлийг таньж мэдсэнээр цаашид тэдгээр хүүхдүүдийг тусгай хэрэгцээнд нь нийцүүлэн үр дүнтэй сургах боломж бүрдэнэ гэж найдаж байна.

# ЭРХ ЗҮЙТ ЁС БА МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү төслийн зорилго нь төрийн байгууллагуудын уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой байгаль хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд мөрдөж буй зарчмыг үнэлэх юм. Үнэлгээ нь эрх зүйт ёсны зарчим хуулинд тусгагдсан эсэх, практик үйл ажиллагаанд мөрдөж буй эсэхийг тодруулах ба төрийн үйлчилгээ хууль ёсны байх, хүртээмжтэй байх зэрэг эрх зүйт ёсны зарчмуудыг ямар хууль, журмуудаар зохицуулж байгааг шинжлэн судална. Үнэлгээний хүрээнд:

- Сонгогдсон, давуу болон сул талыг тодорхойлох
- Үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон ажлын гүйцэтгэлийг хүний эрхийн хандлага болон үйлчилгээ авч буй иргэдийн санал бодлоор дамжуулан үнэлэх
- Хуулиар заасан зохицуулалт болон практикт мөрдөж буй байдал хоёрын зөрүүг шинжлэхийг зорьсон.




# 2016

9-р сар

# 2017

3-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Төслийг Архангай аймаг (Цэнхэр сум) болон Өмнөговь аймаг (Цогтцэций сум) болон Улаанбаатар хотод гүйцэтгэсэн.*

### ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монголын олборлох салбарын хөгжил нь нийгэм болон эдийн засгийн хөгжлийг дэмжихүйц хамгийн гол салбар юм. Гэтэл энэ салбарын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн менежментийн асуудал нь Монгол Улстай адил байгалийн нөөцөөс хамааралтай хөгжингүй орнуудын хувьд хамгийн гол сорилт болдог. Энэ нь ихэвчлэн байгаль орчны менежментийн асуудалд хяналт тавьж ажилладаг байгаль хамгааллын асуудал хариуцсан төрийн байгууллагууд болох агентлаг, яам болон засгийн газар нь салбарыг удирдах бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаагаас үүдэж байна. Энэхүү бүрэн эрх нь байгаль хамгаалах ажлыг удирдан чиглүүлэх, нийгмийн дэвшлийг урагш ахиулах, тогтвортой өсөлтийг хурдасгахыг шаарддаг. Гэсэн хэдий ч, газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын олборлолт нь ихэвчлэн байгаль орчны доройтол, зөрчил, авлига, хүний эрхийн зөрчлийг дагуулдаг.

Улс орнуудыг эдгээр сорилтыг даван туулахад нь туслах зорилгоор НҮБХХ-өөс “Тогтвортой Байгалийн Нөөцийн Менежментийн төлөөх Байгаль Орчны Засаглал” глобал төслийг санаачилсан. Энэ төсөл нь Колумб, Кени, Монгол болон Мозамбик гэсэн улсуудын холбогдох оролцогч талуудын байгаль орчин болон уул уурхайн яамд, холбогдох оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Энэхүү шинэ санаачилгын хүрээнд, НҮБХХ нь уул уурхайн салбар дахь байгаль орчны зохицуулалтыг хариуцан ажиллах үүрэг бүхий БОАЖЯ, МХЕГ-ын үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажилд дэмжлэг үзүүлж байна.

### СУДАЛГААНЫ ДИЗАЙН, АРГА ЗҮЙ

Төслийн хүрээнд НҮБХХ, Шведийн Судалгааны Хүрээлэн, Folke Bernadotte Academy байгууллагын хамтран боловсруулсан судалгааны арга зүйг ашигласан. Энэхүү арга зүй нь төрийн

байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны байдал, хүртээмжтэй байдал, санал бодлоо илэрхийлэх, сонсох эрх, ил тод байдал, гомдол гаргах, давж заалдах эрх, хариуцлагатай байдал гэсэн эрх зүйт ёсны 6 зарчмыг үнэлэхэд зориулагдсан.

Энэхүү үнэлгээ нь 3 хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэг нь хууль, эрх зүйн зохицуулалтын албан зураглал буюу холбогдох агентлагуудын үйл ажиллагаа явуулж буй институцийн орчны зураглал гаргах юм. Үүний хүрээнд, уул уурхай, байгаль орчин, захиргаатай холбоотой 17 хуулинд шинжилгээ хийсэн.

Хоёр дахь хэсэг нь төрийн албан хаагчдын хариуцлагын механизмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын орчинд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх зорилготой санал бодлын судалгаа юм. Энэ судалгааг төрийн байгууллагын анхан шатны нэгжээс сумын түвшин хүртэлх бүхий л удирдлагын түвшинд ажиллаж буй төрийн албан хаагчдаас авсан. Тухайлбал, БОАЖЯ болон

МХЕГ, тэдгээрийн салбар, нэгжүүдэд ажиллаж буй уул уурхай болон байгаль орчны асуудал хариуцан ажиллаж байгаа 65 төрийн албан хаагчдыг үнэлгээнд хамруулсан.

Үнэлгээний гурав дахь хэсэг нь эдгээр агентлагуудын гаргасан шийдвэр, төрийн үйлчилгээг авч буй үйлчлүүлэгчдийн санал бодлын судалгаа юм. Үйлчлүүлэгч гэдэгт иргэд болон аж ахуйн нэгжүүдийг багтааж байна. Тухайлбал, үнэлгээнд уул уурхайн компаниуд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний компаниуд, байгаль хамгааллын чиглэлээр ажиллаж буй ТББ, сонгогдсон аймаг, сумдад амьдарч буй малчид, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийг хамруулсан.

Энэхүү 3 хэсгийн хүрээнд цуглуулсан баримт бичгийн судалгаа болон санал бодлын судалгааны мэдээлэл нь харилцан бие биенээ шалгаж, нөхөн гүйцээнэ.

# “ГОВИЙН ОЮУ” ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ, ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



ГОВИЙН ОЮУ  
ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИХ САН

**IRIM**  
INDEPENDENT  
RESEARCH  
INSTITUTE OF  
MONGOLIA



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

“Говийн Оюу” Хөгжлийг Дэмжих Сан (ХДС)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Зөвлөх үйлчилгээний ерөнхий зорилго нь “Говийн Оюу” Хөгжлийг Дэмжих Сан (ХДС)-ийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн.

Тус зорилгын хүрээнд дараах 4 бүрэлдэхүүн хэсгийн зорилтыг дэвшүүлэн ажилласан.

**Бүрэлдэхүүн 1. Хэлэлцүүлэг:** Түншлэгч сумдуудын иргэд, оролцогч талуудад ХАГ болон сангийн талаарх мэдээлэл түгээх, хэрэгжүүлэх шаардлагатай төслийн талаарх хэрэгцээг тодорхойлох

**Бүрэлдэхүүн 2. Институчлэл:** Байгууллагын чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааны дүрэм журмыг боловсронгуй болгоход чиглэгдэнэ.

**Бүрэлдэхүүн 3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ:** Хэрэгжүүлж буй төслүүдийг сан бие даан хянах ур чадварыг төлөвшүүлэх

**Бүрэлдэхүүн 4. Итгэлийн индекс тооцох:** Стратегийн 3 дахь зорилтыг хэрэгжүүлэх, оролцогч талуудын итгэлийг даасан, хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх. Энэ бүрэлдэхүүн хэсэг нь дотроо хэд хэдэн дэд зорилготой байна. Үүнд:

- Иргэдийн итгэлийн индексийг тооцохын тулд иргэдээс судалгаа авна.
- Мөн иргэдээс хэрэгцээг тодорхойлох зорилготой асуултуудыг багтаасан байна.
- Мөн иргэдэд сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх боломжтой байна.






2017

3-р сар

2018

3-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Өмнөговь аймаг

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

“Оюу Толгой” (ОТ) компани нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй Өмнөговь аймаг болон түншлэгч сумд болох тус аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдтай нийгмийн хариуцлага, орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой Хамтын Ажиллагааны Гэрээг (ХАГ) 2015 онд байгуулан ажилласан нь Монгол Улсын хэмжээнд анхны жишиг болсон билээ.

“Говийн Оюу” Хөгжлийг Дэмжих Сан (ХДС) нь тус гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор үүсгэн байгуулагдсан ба Оюу Толгой компаниас жил бүр олгодог сайн дурын санхүүжилтийг хуваарилан зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Хамтын ажиллагааны гэрээний дагуу талуудын хүлээсэн үүрэг, амлалт болох нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, уламжлалт мал аж ахуй, үндэсний түүх соёл, нийгмийн суурь үйлчилгээ, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих зэрэг үндсэн долоон чиглэлээр Өмнөговь

аймгийн хөгжилд хувь нэмэр оруулах төсөл, хөтөлбөрийн санал хүлээн авч, шалгаруулан санхүүжилт олгодог. Сүүлийн жилүүдэд иргэд, байгууллагаас ХДС-д санхүүжилт хүсч ирүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо эрс нэмэгдэж, тэдгээрийн зорилго, хэрэгжүүлэх үйл ажиллагаа давхцах, нөгөө талаас чанарын шаардлага хангахгүй төслийн тоо нэмэгдэж байгаагаас үүдэн ХДС нь цаашид хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралтуудын дагуу Өмнөговь аймагт нэн шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөрийг тодорхойлон, төсөл хэрэгжүүлэгчийг уралдаант шалгаруулалтаар сонгох тогтолцоонд шилжихээр төлөвлөж байна. Энэ ажлын хүрээнд ХДС-нд одоогийн бодлого, үйл ажиллагааг өөрчлөх, сайжруулах ялангуяа хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн чиглэл бүрээр баримтлах бодлогыг тодорхойлох шаардлага тулгарсан юм.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээний хүрээнд дараах 4 бүрэлдэхүүн хэсэг бүхий үйлчилгээг үзүүлсэн.

Зураг 2. Зөвлөх үйлчилгээний ажлын ерөнхий хүрээ



- 1. Сэдэвчилсэн хавсралт бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулах.** Хэлэлцүүлэг тус бүрт тухайн сэдвийн хүрээнд хамаарах оролцогч талууд болох санхүүжүүлэгч байгууллагын төлөөлөл, орон нутгийн удирдлага, иргэд, экспертүүдийг хамруулсан. Үр дүн нь цаашид тус чиглэлүүдэд баримтлах бодлого, хэрэгцээг тодорхойлсон.
- 2. Институцын чадавхийг бэхжүүлэх.** Орон нутагт хийсэн хэлэлцүүлгүүд болон баримт бичгийн судалгааны үр дүнд тулгуурлан сэдэвчилсэн хавсралт бүрээр баримтлах үндсэн чиглэлийг гаргасан. Мөн энэ бодлогыг хэрэгжүүлэх үйл явцыг шинэчлэн, холбогдох оролцогч талуудын оролцоог тодорхойлж үүнтэй уялдуулан холбогдох баримт бичгүүдийг сайжруулах, боловсруулах үйл ажиллагааг гүйцэтгэлээ.
- 3. Хяналт,-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх.** ХДС-ийн гол үйл ажиллагаа болох төсөл санхүүжүүлэх чиглэлээр төслийн хэрэгжилт, үр дүнг хянах чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байсан. Иймд сангийн ажилтнуудад хяналт,

шинжилгээ үнэлгээний ойлголт, мэдлэгийг олгох сургалт зохион байгуулах, төслүүдэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх дадлагыг олгохын тулд 2 төслийг сонгон явцын болон эцсийн үнэлгээг хийх, тайланг боловсруулах үр чадвар олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

- 4. Итгэлийн индексийг тооцох аргачлал нэвтрүүлэх.** ХДС-ийн стратегийн зорилт 3-ийн хүрээнд хийгдсэн гол үйл ажиллагаа бөгөөд олон улсын жишигт нийцсэн индекс тодорхойлох аргачлал боловсруулан тус санд итгэх иргэдийн итгэлийн суурь индексийг тодорхойлон тайлан боловсруулж өгсөн.

## ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралтууд болох ус болон байгаль орчны менежмент, мал аж ахуй, түүх соёл, аялал жуулчлал, нийгмийн суурь үйлчилгээ, орон нутгийн бизнес хөгжлийг дэмжих зэрэг зургаан хавсралтын хүрээнд баримт бичгийн шинжилгээ болон нийт 9 удаагийн хэлэлцүүлгийг өрнүүлэн, үр дүнд тулгуурлан цаашид баримтлах 3 жилийн үндсэн чиглэлийг боловсрууллаа. ХДС өмнө нь дээрх сэдэвчилсэн хавсралтын хүрээнд төслүүд шууд хүлээн авч, шалгаруулдаг байсан бол цаашид үндсэн чиглэлийг баримтлан ажлын даалгавар боловсруулж, төслийн уралдаант шалгаруулалт хийдэг болох юм.

Өмнөговь аймгийн иргэд, олон нийтийн хэрэгцээнд тулгуурлан хийгдсэн эдгээр үндсэн чиглэлийн дагуу хэрэгжих төсөл хөтөлбөрүүдэд цаашид хяналт-үнэлгээ хийдэг болохоор төлөвлөж байна. Үүнээс гадна иргэдийн итгэлийн индексийг тооцдог болсоноор ХДС нь Өмнөговийн иргэдийн хэрэгцээнд суурилсан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлж байгаа эсэхээ хянах, цаашдын үйл ажиллагааныхаа төлөвлөлтийг тодорхойлоход туслах юм.

# МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД ХИЙСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Европын Холбооны Монгол дахь төлөөлөгчийн газар

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Мэргэжлийн Боловсрол Сургалтын Үндэсний Зөвлөл (МБСҮЗ) түүний өмнө тулгарч буй үйл ажиллагаа явуулж буй орчноос шалтгаалсан өнөөгийн бэрхшээл болон боломжийг судлан илрүүлэх байсан бөгөөд шинжилгээний хүрээнд дараах чиглэлээр судалгаа хийсэн. Үүнд:

- МБСҮЗ-ийн түүх, үүсгэн байгуулсан нөхцөл байдлыг судлах
- МБСҮЗ-ийн оролцогч талуудын үүрэг болон тэдгээрийн үйл ажиллагааны өнөөгийн байдалд шинжилгээ хийх, МБСҮЗ-ийн тогтолцоо, үйл ажиллагааны орчин, бусад харилцагч талуудтай тогтоосон хамтын ажиллагааг судлах
- МБСҮЗ-ийн үйл ажиллагааг зохицуулдаг холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт болон стандартыг судлах
- МБСҮЗ-ийн санхүүжилтийн механизмыг судлах



# 2017

4-р сар

# 2017

8-р сар

## ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

МБС-ын салбарыг шинэчлэхэд Монгол Улсын төрийн байгууллагуудын манлайлын чадавхи сайжирч, МБСҮЗ болон салбар зөвлөлүүдэд дэмжлэг үзүүлэх нь чухал байна. Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын шинэчлэлийн бодлоготой болон донор байгууллагуудын санхүүжүүлж буй төсөл, бусад хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаатай уялдаж байгаа юм.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Шинжилгээний хүрээнд баримт бичгийн шинжилгээ болон ганцаарчилсан ярилцлагыг ашиглан мэдээлэл цуглуулсан.

Арга зүй	Судалгааны гол анхаарлаа хандуулсан зүйлс
Баримт бичгийн шинжилгээ	<ul style="list-style-type: none"> <li>МБСҮЗ-ийн түүх, үүсгэн байгуулагдсан үе</li> <li>МБСҮЗ-ийн тавьсан зорилгууд</li> <li>Хууль эрх зүйн орчин</li> <li>Оролцогч талуудыг тодорхойлох</li> </ul>
Ганцаарчилсан ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогч талуудын үүрэг</li> <li>Оролцогч талуудын үйл ажиллагааны байдал</li> <li>МБСҮЗ-ийн тогтолцоо</li> <li>МБСҮЗ-ийн үйл ажиллагааны орчин</li> <li>МБСҮЗ-ийн санхүүжилтийн механизм</li> <li>МБСҮЗ-ийн үйл ажиллагаанд саад болж байгаа зүйлс болон боломжууд</li> </ul>

Түүнчлэн хоёр удаагийн зөвлөлдөх хэлэлцүүлгийг оролцогч талуудтай хамтран зохион байгуулсан.

1. Эхлэлийн зөвлөлдөх хэлэлцүүлэг: Нөхцөл байдлын шинжилгээний эхний уулзалт хэлэлцүүлгийг оролцогч талуудын дунд ойлголт, мэдээлэл өгөх, санал солилцох зорилготойгоор хийсэн.
2. Хаалтын зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлэг: Нөхцөл байдлын шинжилгээний төгсгөлд шинжилгээний үр дүнг эцсийн тайланд нэгтгэн танилцуулах зорилгоор хаалтын хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн хоёр дахь хэлэлцүүлэгт оролцогчдын санал, зөвлөмжид үндэслэн МБСҮЗ-ийн Нөхцөл байдлын шинжилгээний тайланг гаргасан.

тайланг гаргасан бөгөөд хоёр дахь зөвлөлдөх уулзалтаар талуудад танилцуулж хэлэлцүүлсэн.

Судалгааны гол дүгнэлтүүдийг авч үзвэл:

- Техник мэргэжлийн боловсрол, сургалтын салбар (ТМБС) ялангуяа МБСҮЗ-тэй холбоотой баримт бичгүүд олдоц муутайн дээр ихэнх нь англи хэл дээр байдгаас баримт бичгийн ашиглалт, хүртээмж бага байна. Иймд баримт бичгийн хэрэглээг сайжруулах нь ТМБС-ын салбарт ажиллаж байгаа ажилтнуудын ажлыг хөнгөвчлөх болно.
- Нөхцөл байдлын шинжилгээ хийгдэж байх үед МБС-ын тухай хуулийг шинэчлэх ажил хийгдэж байсан ч МБСҮЗ-тэй холбоотой хууль эрх зүйн орчинд өөрчлөлт ороогүй байна.
- МБСҮЗ-ийн үйл ажиллагаанаас ТМБС-ийн бүх шатны бодлого, хэрэгжилт хамааралтай байдаг.
- 2012-2016 оны хугацаанд МБСҮЗ-ийн хуралдаан маш цөөн хийгдсэнийг

### ҮР ДҮНГҮҮД

Баримт бичгийн шинжилгээ, ганцаарчилсан ярилцлага, эхлэлийн хэлэлцүүлгийн үр дүнгийн мэдээлэл, судалгааны олдворуудад суурилан Нөхцөл байдлын шинжилгээний үнэлгээний

санхүүжилт бага байгаатай холбон тайлбарлаж болохгүй юм. Энэ нь тус зөвлөлд багтах төрийн байгууллагын төлөөллүүдийн халаа сэлгээ, улмаар бодлогын залгамж холбоо алдагдаж байгаатай холбоотой байна.

- ТМБС-ийн салбарын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэхэд нийгмийн түншлэл гол хүчин зүйл нь байдаг. Гэтэл энэ хугацаанд МБСҮЗ нь оролцогч талуудтай бодлого, үйл ажиллагааны хүрээнд харилцах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах чиглэлээр тодорхой үйл ажиллагаа хийгээгүй байна.
- ТМБС-ын салбар нь тогтолцоо болж төлөвшөөгүй байна. ТМБС-ийг ерөнхий боловсрол болон дээд боловсролын тогтолцоотой уялдуулах зайлшгүй хэрэгцээ гарч ирж байгаа ба БСШУСЯ-ны оролцоо нэн чухал байна.

Хоёр дахь зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлгийн үеэр судалгааны дүгнэлтүүдэд санал авч, SWOT шинжилгээг хийх замаар МБСҮЗ-ийн үйл ажиллагааг хэрхэн хянах талаар нэгдсэн байр сууринд хүрсэн юм.

## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Нөхцөл байдлын шинжилгээний үр дүнг МБСҮЗ-ийн ирээдүйн хөгжлийн стратегийн хувилбаруудыг тодорхойлоход ашиглах боломжтой. Нөхцөл байдлын шинжилгээний зөвлөмжийг хоёрдох хэлэлцүүлгийн үеэр танилцуулсан. Үүнд:

- Нөхцөл байдлын шинжилгээний эцсийн тайланг МБСҮЗ-д танилцуулсан ба бусад баримт бичгүүдийн хамтаар холбогдох газруудын веб сайтанд байрлуулсан. Ингэснээр дараа дараагийн судалгаанд ашиглах судалгааны мэдээллийг нэг дороос авах боломжтой.
- МБСҮЗ нь Засгийн газар, ажил олгогч, ажилчин болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талуудыг төлөөлсөн гурван талт гишүүдээс бүрдэх хэрэгтэй.
- Зөвлөлийн удирдлагыг томилохгүй гишүүдээс сонгоно.
- Үндэсний Хөгжлийн Агентлаг болон БСШУЯ-ны төлөөллүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх хэрэгтэй.
- Зөвлөлийн үйл ажиллагаа нь итгэмжлэгдсэн ажлын албатай байх ба тухайн алба нь МБСҮЗ-ийн шийдвэрүүдийг бэлтгэх, боловсруулах, тараах, түгээх, хэрэгжилтэнд хяналт тавих, ээлжилт хуралдааныг зохион байгуулна. Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөр Эрхлэлтийн Сангийн гадаад ажилтнуудаас орж ирсэн орлогоос бүрдүүлж болно.

# ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТ (ҮДСНМ)-ИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



САНГИЙН ЯАМ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Европын холбооны Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах Сайн засаглал (EG4EG) төсөл

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг зөвлөх үйлчилгээний зорилго нь Монгол улсын засгийн газрын хөгжлийн хөтөлбөрийн хяналт, үнэлгээний хэрэгжилтийг сайжруулах замаар Монголын хөгжлийн бодлого төлөвлөлтийн менежментийн циклийг сайжруулах төслийн үйл ажиллагааны сүүлийн шат болох төрийн байгууллагуудын чадавхийг сайжруулах явдал юм.

Төслийг Малайзаас ирсэн олон улсын зөвлөх Ph.D Арунаселам Расаппан (Dr. Arunaselam Rasappan Ph.D) ИРИМ-ийн зөвлөх Ч.Тамир нарын олон улсын болон дотоодын зөвлөхийн хамтарсан баг Сангийн яаман дээр хэрэгжүүлсэн.

Гол үйл ажиллагаа нь сангийн яамны мэргэжилтнүүд жилийн болон хагас жилийн төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлангуудыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан 'Бодлогын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам'-ын заалтуудад нийцүүлэн, Сангийн яамны мэргэжилтнүүдийн хяналт, үнэлгээний тайлан, стандартыг сайжруулахын ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх явдал юм.



2017

8-р сар

2017

12-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Европын холбооны санхүүжилттэй Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах Сайн засаглал (EG4EG) төсөл нь 2016 оноос нь тэгш хүртээмжтэй өсөлтийг дэмжсэн бодлого, дэд бүтцийг бий болгох шаардлага бүхий бодлого, стратеги төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яам гэх мэт холбогдох яамдуудтай нягт хамтран ажиллаж байна. Уг төсөл нь 2015 оны 11 дүгээр сард Засгийн газрын 249 тогтоолоор батлагдсан 'Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль' болон Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан 'Бодлогын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам'-ын зүйл, заалтуудтай нийцүүлсэн байдлаар хөгжлийн төлөвлөлт, хяналтыг сайжруулах санал зөвлөмж боловсруулсан. Уг санал, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангахын тулд 'Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн хөтөлбөр'-ийг боловсруулж туршилт хийсэн. Хөтөлбөрийг боловсруулахдаа хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг үндэсний бодлого хөтөлбөрүүдтэй уялдуулж, урьдчилсан үр нөлөөний шинжилгээ, зардал, санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газрын жилийн төсөвт оруулж, төсвийн хэрэгжилтийн хүрээнд Сангийн яам, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд Засгийн газрын хяналт, үнэлгээний шаардлагад нийцсэн үйл ажиллагаа, арга хэмжээг авсан. Уг туршилтын үр дүнд Хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай Засгийн газрын чадавхи болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хоорондын холбоо хамаарлыг сайжруулах, шаардлагатай алхмуудыг тодорхойлсон.

2017 онд Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах Сайн засаглал (EG4EG) төсөл нь Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт болон хяналт, үнэлгээ хоорондын уялдаа холбоог сайжруулж, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн менежментийн циклийг сайжруулах төслийн сүүлийн шатны үйл

ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлээ. Уг үйл ажиллагаа нь үндэсний болон Сангийн яамны гэсэн хоёр түвшинд хэрэгжсэн.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээний хүрээнд төслийн зөвлөх баг 'идэвхитэй оролцооны арга'-ыг ашигласан. Төслийн гол бүрэлдэхүүн хэсэг нь сургалт, дагалдуулан сургах гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэж байв. Сургалт нь гурван үе шаттай явагдсан ба эдгээр нь нэгд, мэдлэг, ойлголт өгөх сургалт, хоёрт, техникл сургалт, гуравт төсвийн төлөвлөлтийн сургалт зэрэг болно.

**Дагалдуулах сургалт:** Үндэсний зөвлөх Ч.Тамирын удирдлаган доор Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газар, Санхүүгийн бодлогын газар, Төрийн сангийн бодлогын газар, Төрийн захиргааны удирдлагын газар, Төсвийн бодлогын газар гэсэн таван газарт хийгдсэн бөгөөд тус газрыг төлөөлсөн багууд нь өөрсдийн даалгаврыг хийж гүйцэтгэн улмаар удирдлагуудын семинарт танилцуулсан.

**Сургалт, хэлэлцүүлэг:** ҮДСНМ-ийн талаар мэдээлэл өгөх сургалт-хэлэлцүүлэг болон олон талт оролцогчдыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сургалт, хэлэлцүүлгийн үеэр мэргэжилтнүүдээс ҮДСНМ-ийн тогтолцоо, хандлага, хэрэглэгдэхүүн, арга барил, хариуцсан хүмүүс зэргийн талаар мэдээлэл авч, мэргэжилтнүүд асуулт асууж, санал бодлоо хуваалцаж, уг тогтолцоог өөрсдөө үнэлэх боломжийг олгосон.

Хэлэлцүүлэг бүрийн үр дүнг хэмжих зорилгоор хэлэлцүүлгийн өмнө болон дараа тест авч сургалт-хэлэлцүүлгийн дүнд оролцогчдын мэдлэг, мэдээлэл сайжирсан эсэхийг үнэлж байв.

## ҮР ДҮНГҮҮД

Зөвлөх үйлчилгээний үр дүнд холбогдох яамны мэргэжилтнүүдийн ҮДСНМ-ийн тогтолцоог хэрэглэх мэдлэг, чадвар сайжирсан. Мөн хэлэлцүүлгийн оролцогч талууд ҮДСНМ-ийн

тогтолцооны зарчим, хэрэглэгдэхүүн зэргийг хөтөлбөрийн стратегийн үр дүн, төлөвлөлт болон хяналт, үнэлгээндээ ашиглах ойлголт, ач холбогдлыг нь ойлгох, хэрэглэх байдал нэмэгдсэн байв. Зөвлөх үйлчилгээний зорилтот байгууллагуудаас гадна ҮДСНМ-ийн тогтолцоог Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Үндэсний Хөгжлийн Газар, Үндэсний Статистикийн Хороо болон Үндэсний Аудитын газар зэрэг байгууллагууд хэрэглэх, өөрсдийн байгууллагатаа нэвтрүүлэхийг хүсч байгааг илэрхийлж байв. Судалгааны үр дүнгээс харахад зорилтот яам болох Сангийн яамны хяналт, тайлагналтын үйл ажиллагааны хэрэгжилт доголдолгүй явж байгаа мэт боловч байнгын даяарчлагдаж буй эдийн засгийн хөгжлийн санаачлагуудаас гаргасан шаардлагуудад нийцэхийн тулд сайжруулах шаардлагатай зүйлс, сорилтууд их байна.

## **ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ**

Зөвлөх үйлчилгээ нь Сангийн яамны мэргэжилтнүүдийн үр дүнд суурилсан менежментийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан төдийгүй тэдгээр мэргэжилтнүүд Сангийн яам, Засгийн газар, төрийн байгууллагуудын цаашдын хяналт, үнэлгээг сайжруулна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлж байв.

Эцэст нь дүгнэхэд үр дүнд суурилсан хяналт, үнэлгээ болон үр дүнд суурилсан төсөвлөлт зэргийг төрийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, улс орны хөгжлийн үр дүнг сайжруулахад чухал нөлөөтэй.



## МОНГОЛ ДАХЬ АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН СУДАЛГАА



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

АНУ-ын Азийн сан - Монгол

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь Улаанбаатар хот болон Увс, Дархан аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа 19 арьс ширний үйлдвэрүүдээс мэдээлэл цуглуулан нөхцөл байдлын шинжилгээ хийх, энэ салбарт чиглэсэн хөгжлийн стратегийг тодорхойлох, нөлөөллийн үйл ажиллагааг эрэмбэлэх юм.



# 2017

7-р сар

# 2017

10-р сар

**ХАМРАХ ХҮРЭЭ**

*Төслийг Улаанбаатар хот, Дархан, Увс аймагт хэрэгжүүлсэн.*

## **ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

Монгол дахь арьс ширний үйлдвэрлэлийн салбар нь ажил эрхлэлт болон орлогын хувьд бага хувийг эзэлж байгаа ч дотоодын нийт бүтээгдэхүүний чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Эдийн засгийн уналтын үед энэ салбар хуваагдаж, уналтад орсон. Өмнө нь төрийн өмчийн арьс ширний үйлдвэр байсан бол, одоо олон жижиг хувийн үйлдвэрүүд ажиллаж байна. Үйлдвэрлэл эрхэлж байгаа байгууллагуудад тулгардаг нийтлэг бэрхшээлээс гадна жижиг арьс ширний үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа бэрхшээлүүдийг авч үзвэл:

- Хятадын арьс ширний салбарын дэлхийн түвшин дэх байр суурь
- Машин, тоног төхөөрөмжийн өндөр өртөг
- Өндөр технологийн бохир ус цэвэрлэх систем
- Чадварлаг боловсон хүчин дутмаг гэх мэт

Өнөөдөр Монгол дахь арьс ширний салбарын талаарх мэдээлэл, судалгаа дутмаг, үндэсний түвшинд энэ салбарын худалдааны мэдээлэл байхгүй байна. Хэдий тийм боловч, Европын холбооны төслийн хүрээнд бүрдүүлж байсан цөөн тооны хуучны баримт бичгүүд үлдсэн байдаг. Энэ асуудлууд нь тус салбарын хөгжил харьцангуй удаашралтай байгааг харуулж байгаа ба уг төслийн судалгааг хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

## **СУДАЛГААНЫ ДИЗАЙН, АРГА ЗҮЙ**

Судалгааны арга зүйг АНУ-ын Азийн Сан Монгол болон IRIM Судалгааны Хүрээлэн нар хамтран боловсруулсан. Арга зүйн хүрээнд асуумжийн судалгааг ерөнхий асуулт, бизнесийн үйл ажиллагаа, салбарын чадавхи, хэрэгцээ, арьсан бүтээгдэхүүн гутлын үйлдвэрлэл, арьс шир идээлэх, худалдаатай холбоотой мэдээлэл, үйлдвэрлэл болон санхүү гэсэн есөн бүлгийн 43 асуултуудаар авсан. Мөн оролцогч талуудтай ярилцлага хийсэн. Эдгээр судалгааны хэрэглэгдэхүүнийг туршилт судалгааны үеэр сайжруулан эцэслэсэн. Талбарын судалгааны мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд дараах чиглэлээр мэдээлэл авсан. Үүнд:

- 17 компаниас асуумжийн аргаар мэдээлэл цуглуулсан.
- Оролцогч талуудтай ярилцлага /5/ хийсэн.
- Баримт бичгийн судалгааг гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүнд уг салбарын хөгжилтэй холбоотой нэн тэргүүний асуудлууд, боломж, бэрхшээл зэргийг тодорхойлж, стратегийн чиглэлийг тодорхойлсон.

## **СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ**

Судалгаанд оролцогчдын олонхи нь арьс ширний үйлдвэрлэлийг бэлтгэн нийлүүлэх түүхий эдээр баялаг гэдэгтэй санал нийлсэн. Гэвч, эдгээр түүхий эдийн хүртээмжийн хувьд дараах асуудлууд тулгардаг байна. Үүнд:

- Олонхи арьс, шир нь маш богино хугацааны туршид л олдоцтой байдаг
- Олонхи арьс, ширийг төрөлжүүлэн шилэх боломж хомс байдаг
- Олонхи арьс ширийг албан бус буюу худалдааны бус зориулалтаар нядалсан байдаг

Үүнээс гадна, мал сүрэгт аюул учруулахуйц зуд тохиолдсоноор 4 хүртэлх жилээр арьс, ширний ханган нийлүүлэлт зогсох томоохон эрсдэл бий болдог ажээ.

Монголын арьс шир үйлдвэрлэгчдийн хэлж байгаагаар, урт болон дунд хугацаанд арьс, ширний ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломж хомс байгаа ч, багахан боловсруулалт хийн экспортоор гаргаж буй арьс, ширийг илүү боловсруулж, үнэ цэнийг нь нэмэгдүүлэх боломж бий. Гэхдээ энэхүү боломжийг үр ашигтай, үр дүнтэйгээр ашиглахын тулд түүхий эдийн чанарын талаар илүү их мэдээлэл шаардлагатай болж байна. Судалгаанд оролцогчид хэлсэнчлэн, одоогийн арьс, ширний үйлдвэрүүд түүхий эдийн нядалгааны өмнөх болон дараах үеийн гэмтлийг бууруулахаас илүүтэйгээр арьс ширийг дахин боловсруулах явцад илэрч гэмтлийг засварлахад хамаг хүчээ зарцуулж байна.

Арьс, ширний чанарыг сайжруулах, боловсруулах ажлыг хөнгөвчлөх асуудлууд хэдийгээр судалгаагүй боловч, цаашид зайлшгүй анхааран авч үзэх шаардлагатай.

# ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВЛӨРӨЛИЙГ СААРУУЛАХ ТУХАЙ ИРГЭДИЙН САНАЛ БОДЛЫН СУДАЛГАА



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

АНУ-ын Азийн Сан - Монгол

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Хотын засаглалыг сайжруулах төсөлтэй холбоотой. “Хотын засаглалыг сайжруулах төсөл”-ийн үр дүн 2 нь дараах хоёр гарцаас бүрдэнэ. Үүнд:

- 2.1. Сонгогдсон төрийн үйлчилгээний үйл явцын зураглал гаргах
- 2.2. Сонгогдсон гурван төрийн үйлчилгээг сайжруулах төлөвлөгөөг холбогдох агентлагуудтай хамтран боловсруулах

Улаанбаатар хотын дөрвөн байршлийн 14 төрийн үйлчилгээнээс нэг ба түүнээс дээш ашиглагддаг тодорхой бүлгүүд дээр шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнд суурилан төвлөрлийг сааруулах шаардлагатай төрийн үйлчилгээнүүдийн эрэмбийг дүүргийн болон хорооны түвшинд тогтоох зорилготой ажилласан.



# 2017

8-р сар

# 2017

12-р сар

## ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотын Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Налайх дүүрэгт хэрэгжүүлсэн.

## ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

АНУ-ын Азийн Сан - Монгол (АС) нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)-тай хамтран Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Хотын Засаглалыг Сайжруулах Төслийг хэрэгжүүлж байна. Төсөл 2018 оны 12 сар хүртэл (3.5 сар) үргэлжлэх бөгөөд гол зорилго нь иргэдийн хэрэгцээг хангахуйц тогтвортой үйлчилгээг үзүүлдэг итгэмжлэгдсэн, ардчилсан, хариуцлагатай орон нутгийн засаг захиргааг бий болгох юм. Түүнчлэн “Хотын засаглалыг сайжруулах” төсөл нь амжиргааны түвшин доогуур иргэдэд чиглэсэн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, зорилтот нийгмийн халамжийн үйлчилгээг хорооны түвшинд хүргэх туршилтыг явуулахад дэмжлэг үзүүлнэ. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар дараагийн хэдэн жилүүдэд аль болох олон үйлчилгээг хорооны түвшинд иргэдэд ойртуулахаар төлөвлөж байгаа билээ. Түүнчлэн тэдгээр үйлчилгээ ихэвчлэн амжиргааны түвшин доогуур иргэд болон эмэгтэйчүүдэд чиглэсэн байхаар зорьж байгаа юм. Судалгааны зорилго нь иргэдийн авч буй 14 үйлчилгээ (хотын газрын алба, иргэний бүртгэл, архивын газар гэж ангилагдсан) иргэдэд хэрхэн хүрдэг талаар судлах, эдгээр үйлчилгээний талаар илүү сайн ойлголттой болох мөн үйлчилгээ талаарх иргэдийн үзэл бодол болон саналыг сонсох байв.

## СУДАЛГААНЫ ДИЗАЙН, АРГА ЗҮЙ

Судалгааны мэдээллийг Улаанбаатар хотын 4 байршилд ярилцлага, хэлэлцүүлэгийн аргаар цуглуулсан. Улаанбаатар хотын 100 өрхийн төлөөлөл болон 300 нэг цонхны үйлчлүүлэгчдээс асуулгаар мэдээлэл цуглуулсан. Мөн зорилтот 14 төрийн үйлчилгээний чиглэлээр 14 бүлгийн ярилцлагад 112 хүн хамрагдсан ба иргэд өнгөрсөн жилийн туршлага дээрээ тулгуурлан мэдээлэл өгсөн.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны үр дүнд төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж, төрийн үйлчилгээний үе шатыг тодорхойлох, төвлөрлийг сааруулах шаардлагатай төрийн үйлчилгээнүүдийн эрэмбийг дүүргийн, хорооны түвшинд тогтоохоор зорьсон. Судалгаанд оролцогчид өөрсдийн туршлагадаа үндэслээд 14 үйлчилгээний талаар үнэлгээ өгсөн ба ихэвчлэн “сайн” ба “боломжийн” хэмээн үнэлсэн. Мөн төрийн байгууллагад иргэд санал гомдлоо илэрхийлэх байдал харьцангуй өндөр (7.5%) байгаа ба гомдол санал гаргахыг хүссэн ч төвөгшөөх хүмүүс олон байна. Одоо байгаа үйлчилгээнүүдийг сайжруулах талаар маш олон санал гарсан бөгөөд эдгээрээс дурдвал:

- Хүлээлгийн цагийг багасгах (дараалал болон үйлчилгээ)
- Үйлчилгээний үргэлжлэх, дуусах хугацааг багасгах (үйлчилгээний процесс эхлэлээс дуусах)
- Зочлох (эргэж ирэх явдал) тоог багасгах
- Харилцагчийн үйлчилгээг ерөнхийд нь сайжруулах
- Интернет банкаар төлбөр төлөх боломжийг нэмэх
- Ухаалаг гар утас, мобайл аппликэйшн гэх зэрэг үйлчилгээг ашиглах боломжийг нэмэх

## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төрийн үйлчилгээг эрэмбэлж, төвлөрлийг сааруулах шаардлагатай үйлчилгээг сонгох нь хүндрэлтэй байна. Учир нь ямар шалгуураар сонгохоос шалтгаалж эрэмбэ өөрчлөгдөж байгаа юм. Судалгаанд оролцогчдын дунд төрийн үйлчилгээний хэрэглээ хамгийн багадаа 2%, хамгийн ихдээ 38.7% байсан бөгөөд үйлчилгээ нь илүү иргэдэд ойр байх тусмаа хэрэглээ нь өсөх хандлагатай байна. Иймээс үйлчилгээг

эрэмбэлэхдээ хэрэглэгчдийн үнэлгээ, тухайн үйлчилгээ авахад төвөгтэй байдал, шаардах нийт хугацаа гэх зэрэг өөр төрлийн шалгуурууд хэрэглэх шаардлагатай. Тус шинжилгээн дээр үндэслэн төрөл бүрийн боломжит (төвлөрлийг сааруулахад тохиромжтой үйлчилгээнүүдийн) сонголтууд гарч ирэх бөгөөд үүнд их ялгаатай 2 хувилбар байна.

- **Сонголт 1:** Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архиваас эд хөрөнгөтэй эсэх лавлагаа, Байгууллага, иргэдийн нотариатаар гэрчлүүлсэн үйлдлүүд дээрх лавлагаа, Нийслэлийн нутаг дэвсгэрт газар өмчлөөгүй тухай тодорхойлолт авах үйлчилгээнүүд
- **Сонголт 2:** Газар өмчлөх, эзэмших эрхийг шилжүүлэх, Газар өмчлөх, эзэмших,

ашиглах эрхийг баталгаажуулах, Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх үйлчилгээнүүд

Сонголт 1-д хамрагдсан үйлчилгээнүүд нь ерөнхийдөө сайн үнэлгээтэй, хурдан, хялбар ба жишиг үйл явцын зураглал хийгдээгүй. Эсрэгээр, Сонголт 2-д хамрагдсан үйлчилгээнүүд нь үнэлгээ муутай, удаан, төвөгтэй үйл явцтай бөгөөд жишиг үйл явцын зураглал хийгдсэн үйлчилгээнүүд юм.

Сонголт 1-ийн хувьд төвлөрлийг сааруулахад илүү хурдан, хялбар авах боломжтой үйлчилгээнүүдийг санал болгож байгаа бол Сонголт 2 нь илүү удаан болон илүү төвөгтэй байна. Судалгааны ажил дууссан дараа зохион байгуулах “Мэдээлэл тархах” хэлэлцүүлэг дээр эцсийн сонголт нь аль нь байж болохыг хэлэлцэх юм.

# БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ (ОЙН САЛБАРЫН ЖИШЭЭ)



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

**giz**

Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH

**IRIM**  
INDEPENDENT  
RESEARCH  
INSTITUTE OF  
MONGOLIA



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН),  
Байгаль орчин, Аялал жуулчлалын яам (БОАЖЯ)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Уг судалгаа нь хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй. Нэгдүгээр хэсэг буюу 'Байгаль орчны салбарын жэндэрийн тэгш байдлын шинжилгээ' нь байгаль орчны салбар дахь шийдвэр гаргалтад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангах, байгалийн баялгаас тэгш хүртэхэд шаардлагатай мэдээлэл буюу ойн салбарын жэндэрийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдлыг гаргаж ирэх зорилготой. Харин хоёрдох хэсэг буюу 'Жэндэрийн үнэлгээ' нь 'Байгаль орчны салбарын жэндэрийн стратеги (2014-2030)'-ийн I шатны хэрэгжилтийн хүрээнд гарсан ахиц, ололт амжилт, сорилт болон саад тогторуудыг Стратегийн ач холбогдолтой байдал, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал болон тогтвортой байдлын хүрээнд үнэлэх зорилготой.




# 2017

9-р сар

# 2018

2-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот, Сэлэнгэ, Завхан, Булган, Хөвсгөл, Хэнтий аймгууд

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Жендэрийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх нь “уур амьсгалын дулааралтай тэмцэх суурь зарчим” гэдгийг судалгаануудад дурдсан байдаг. Тиймээс Парисын тунхаглал (2015) болон Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн хүрээнд олон улсуудтай хамтарч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, чадавхижуулах зэрэгт жендэрийн мэдрэмжтэй хандлагыг баримтлах шаардлага тулгараад байна. (BMZ and GIZ 2017). Монгол орны нөхцөлд байгаль орчны шийдвэр гаргалтанд олон нийтийн ба эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог хангах болон хөдөөгийн иргэдэд байгаль орчны доройтлоос үзүүлэх сөрөг нөлөөг багасгах зэрэг нь Монголын хувьд нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай асуудлууд болоод байна. Монгол Улсын Засгийн газар (МУЗГ)-аас бүх салбарт (байгаль орчны салбарыг оруулаад) жендэрийг нэвтрүүлэхэд ахиц гарган ажиллаж байна. Жишээлбэл, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), Ногоон хөгжлийн бодлого (2014-2030), МУ-ын урт хугацааны

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2016-2030) зэргийг батлаад байна. МУЗГ-аас байгаль орчны салбарын жендэрийн тэгш байдалд ач холбогдол өгч байгаа ч энэ асуудалтай холбоотой судалгаа ховор байна. Түүнчлэн, ойн салбар бол эрэгтэй хүний мэргэжил давамгайлсан салбар гэсэн нийтлэг ойлголт нь ойн салбарын судалгаанд жендэрийг багтаахад саад болж байна. Цаашилбал, ойгоос хүртэж буй нийгмийн үр ашгийг хэмжихэд хүндрэлтэй учир ойн нийгмийн гүйцэтгэх үйлчилгээний байдал болон нийгмийн үр ашгийн талаар нотолгоо, мэдээлэл хомс байна.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

**Бүрэлдэхүүн 1: Байгаль орчны салбар дахь жендэрийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн шинжилгээ (ойн салбарын жишээгээр)**

Шинжилгээний хүрээг гаргахдаа НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (ХХААБ)-аас гаргасан ‘Ойн салбарт жендэрийг асуудлыг тусгах нь’ гарын авлага ашигласан ба Тогтвортой

хөгжлийн зорилтын гурван тулгуур багана болох 'эдийн засгийн хөгжил', 'нийгмийн тэгш оролцоо', 'байгаль орчны хамгаалал'-ийн зарчим дээр үндэслэж шинжилгээ хийсэн. Түүнчлэн ойн менежментэд эмэгтэйчүүдийг оролцуулах нь ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх ба ингэснээр ашгаас тэгш байдлаар хүртэх, бодлогын хэрэгжилтийн ашиг нэмэгдэнэ гэдэг таамаглалыг дэвшүүлсэн.

Судалгаанд ойн аж ахуйн үйл ажиллагаанд оролцож буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлага, жендэрийн талаарх мэдлэг, ойлголт, ажил эрхлэлтийн байдал, ойн аж ахуйн үйл ажиллааны засаглал, ойн тогтвортой менежментийн хөгжлийн өнөөгийн түвшинтэй холбоотой асуудлуудыг хамруулан судалсан. Ингэхдээ Улаанбаатар хотод болон ой бүхий аймгуудаас холбогдох оролцогч талуудтай хагас бүтэцчилэгдсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

Зураг 1. Судалгаанд хамруулсан оролцогч талууд



## Бүрэлдэхүүн 2: Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014-2030)-ийн 1 дүгээр шатны хэрэгжилтийн үнэлгээ

Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014-2030)-ийн I дүгээр шатны хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэхдээ Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллын Хөгжлийн тусламжийн хороо (OECD-DAC)-ны үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан. Эдгээрт ач холбогдолтой байдал, үр дүнтэй байдал, үр ашигтай байдал, тогтвортой байдал багтана. Мөн Стратегийн хяналт, үнэлгээний тогтолцоонд

үнэлгээ хийсэн. Эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийт 42 асуултаас бүрдсэн хоёр төрлийн хэрэглэгдэхүүн боловсруулж, 'Ажилчдын судалгаа', ганцаарчилсан ярилцлагуудыг дээр дурдсан оролцогч талуудтай хийсэн.

## ҮР ДҮНГҮҮД

Байгаль орчны салбар дахь жендэрийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн шинжилгээ (ойн салбарын жишээгээр)-гээр ой болон жендэртэй холбоотой дараах дүр зураг харагдаж байна.

1. Жендэрийн тэгш бус байдлын олон талт хамааралтай байдлыг авч үзэх хэрэгтэй. Жишээлбэл, хот, хөдөөд жендэрээр ялгаатай боловсролын тэгш бус байдал гэх мэт тэгш бус байдлын олон хэлбэрүүд Монголд гарч байна.
2. Байгаль орчин, хүмүүс хоорондын холбоо, харилцааг өнгөцхөн байдлаар ойлгох байгаль орчны нийгмийн сайн сайханд үзүүлэх үр нөлөөг орхигдуулж зөвхөн ядуурал зэрэгтэй холбож ойлгох явдал байна.
3. Ойтой холбоотой хууль эрх зүй, бодлогын чиглэлүүд нь илүү байгаль орчныг хамгаалахад чиглэсэн ба ойн эдийн засгийн болон нийгмийн үүргийг бараг орхигдуулсан байна. Жендэр болон байгаль орчинтой холбоотой хууль, дүрмийн биелэлт сул хэвээр байна. Үүнд хариуцлагын тогтолцооны сул байдал, байгууллагын мэдлэг, нөөц гэх мэт чадавх дутмаг зэрэг маш олон хүчин зүйл нөлөөлж байна.
4. Ойн салбарт эрэгтэй хүмүүс биеийн хүч шаардсан ажилд илүү оролцоотой байгаа бол эмэгтэйчүүд ойд үржүүлэг, цэвэрлэгээ гэх мэт ажлуудыг илүүтэй хариуцан хийж байна. Оролцогч талууд Монгол дахь ойн бизнесийг эрэгтэй хүмүүс давамгайлсан салбар гэж үзэж байгаа ба энэхүү хандлага нь эрэгтэй хүмүүсийн дунд илүү зонхилж байна.
5. Ойн салбар дахь ажил эрхлэлтийг жендэр, боловсрол, хүйсээр авч үзсэн. Хэдийгээр ажилгүйдлийн түвшин өндөр байгаа ч ойн нөхөрлөлүүдэд залуу хүмүүсийн оролцоо бага байна.
6. Ойн компаниуд болон ойн нөхөрлөлүүдэд маш олон бэрхшээл учирч байна. Орон




нутгийн удирдлагууд үүрэг, хариуцлагын талаар мэдлэг, ойлголт дутмаг байгаагаас үүдэн тэдэнд учирч буй бэрхшээлүүдээс болон санхүүжилт хомс байгаагаар нэрлэгдээд зогсохгүй зах зээлийн орчин таагүй, чадавхаа сайжруулах боломж хязгаарлагдмал, ойн менежментэд оролцох оролцоо дутмаг байна.

7. Байгаль орчны салбарын шийдвэр гаргалтад эмэгтэй хүмүүсийн оролцоо эрэгтэй хүмүүстэй харьцуулахад бага байна. Жендэрийн асуудлуудын талаар ойлголт, мэдлэг дутмаг байгаагаас шалтгаалаад жендэрийг нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих дэмжлэг бүх түвшиндээ доогуур байна.

Судалгааны хоёрдох бүрэлдэхүүн хэсэг буюу Байгаль орчны салбарын жендэрийн стратегийн 1 дүгээр шатны хэрэгжилтийн үнэлгээний дүнгээс харахад Стратегийн 1 дүгээр шатны хэрэгжилт маш сул байв. 21-н индикатороос ердөө 4 нь буюу 19%-тэй нь холбоотой үйл ажиллагаа хийгдсэн. Тэдгээрийн ихэнх нь донор байгууллагын санхүүжилт, санаачилгатайгаар хэрэгжсэн байв.

Стратегийг хэрэгжүүлэгчид гэх мэт оролцогч талууд стратегийн хэрэгжилт үр ашиггүй байсныг дурьдаж байсан ба оролцогч талууд, мэдээлэл солилцоо, хяналт, үнэлгээ дутмаг, оролцогч талуудын оролцоо дутмаг байсан талаар дурдаж байв. Донор байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчидтэй ярилцлага хийхэд уг Стратегийн байдаг эсэх талаар мэдэхгүй байх тохиолдлууд их байв. Цаашилбал, Стратеги нь дизайн талаасаа дутагдалтай талууд ажиглагдсан. Жишээлбэл, стратегийн боловсруулалт, индикаторуудын тохиромжгүй байх явдал их байсан ба үр дүнд суурилсан менежментийн зарчмуудыг баримтлаагүй байна. Стратегийн хүрээнд гарсан ахиц, ололт амжилтыг хэмжихэд шаардлагатай индикаторуудын чанар болон тохиромжтой байдал сул байсан тул Стратегийн хүрээнд гарсан ахицыг хэмжихэд хүндрэлтэй байв. БОАЖЯ-н дээр зохион байгуулсан 'Ажилчдын судалгаа'-ны үр дүнгээс харахад Стратегийн хэрэгжилтийн үнэлгээний дундаж нь нийт 5-н онооноос 2.62-3.27 дундажтай байв.

Зураг 2 Ажилчдын судалгаа: Стратегийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дундаж оноо



## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Судалгааны үр дүнгээс харахад байгаль орчны салбарт, ялангуяа ойн салбарт эмэгтэйчүүд боловсрол, эрүүл мэнд гэх мэт шаардлагатай 'чадамж'-ийг эзэмшсэн байгаа ч тухайн чадамжаа ашиглах, боломж, давуу тал болгох байдал ойн салбарт дутмаг байна. Тиймээс эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай дараах санал, зөвлөмжийг боловсруулсан.

1. Ойн бодлого, үйл хэрэгт учирч байгаа жендэртэй холбоотой асуудлуудын талаар бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх, үндэсний

болон дэд салбаруудын түвшинд зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах

2. Жендэрийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн талаар хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх, ингэхийн тулд Жендэрийн Үндэсний Хороо (ЖҮХ) болон холбогдох байгууллагуудтай хамтран сургалт, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг нөлөөллийн үйл ажиллагаатай хавсаргасан зохион байгуулах
3. Илүү бүх нийтийг хамарсан, жендэрийн мэдрэмжтэй ойн тогтвортой

менежментийг бий болгохын тулд ойн нөхөрлөлүүдэд тулгардаг асуудлуудыг авч үзэх, шийдвэрлэх хэрэгтэй. Жишээлбэл, ойн нөхөрлөлүүдийн ойн нөөцөөс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх боломжийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийх шаардлагатай ба ойн тогтвортой менежментийг аялал жуулчлал болон жижиг дунд бизнесийн талаарх бодлоготой уялдуулах талаар судалгаа хийх хэрэгтэй. Цаашлаад ойн тогтвортой менежментийг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд оруулах байдал шинжилгээ хийх хэрэгтэй. Жишээлбэл, тэд эмзэг бүлгийнхнийг багтаасан, орон нутгийн удирдлагууд ойн тогтвортой менежментийг дэмжиж, энэ ойлголтыг ашиглаж байгаа эсэхэд шинжилгээ хийх. Ойн нөхөрлөлүүдийн залуу гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй.

4. Албаны болон иргэний нийгмийн түвшинд байгаль орчны бодлогын түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Ингэхийн тулд хэрэглэж болох олон аргуудын нэг нь Жендэрийн тэгш байдлын хангах тухай хууль (ЖТБХТХ)-д заасан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүйсийн квотыг төрийн байгууллагууд бүх түвшиндээ хангаж ажиллах ба Төрийн албаны зөвлөл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий стандартын хэрэгжүүлэлтийг сайжруулах хэрэгтэй.
5. Байгаль орчны (ойн) салбарт жендэрийг нэвтрүүлэх удирдамж боловсруулах. Уг удирдамжид жендэрийн стратегийг хэрэгжүүлж, нэвтрүүлэх, жендэрийн тэгш байдлыг байгаль орчны салбарын төлөвлөлт, төсвийн үйл явцад хэрхэн нэвтрүүлэх талаар илүү онцлон төвлөрч багтаасан байх хэрэгтэй
6. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудыг чадавхитай болгох. Ойн салбарт гүйцэтгэх орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын үүрэг, роль маш чухал байдаг. Учир нь тэд салбараас баталсан бодлого, стратеги, төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэдэг. Байгаль орчны салбарын жендэрийн стратеги болон бусад бодлогуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд жендэрийг тухайн салбарт нэвтрүүлэхэд шаардлагатай чадавхтай

байх хэрэгтэй.

7. Ойн салбарын ажил эрхлэлтийн талаар хүйсийн задаргаатай мэдээллийг бий болгох. Ойн салбар дахь хүйсийн задаргаатай, нийгэм эдийн засгийн мэдээллийг бий болгож, олон нийт ашиглахад нээлттэй болгох хэрэгтэй. Холбогдох мэдээллийг цуглуулж, ашиглаж буй мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, жендэрийг нэвтрүүлэх сайн туршлагыг орон нутгийн захиргааны байгууллагууд, БОАЖЯ төдийгүй донор байгууллагуудаас санхүүжиж буй төслүүдийн хүрээнд сайжруулах хэрэгтэй.

Эцэст нь дүгнэхэд, Стратеги нь бодлого, хүн амын хэрэгцээ талаасаа ач холбогдолтой, үндэсний бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байв. Стратеги нь жендэрийг үндэсний түвшинд нэвтрүүлэхэд илүү чиглэсэн ба ингэхийн тулд байгууллагын чадавхыг эхлээд сайжруулах хэрэгтэй гэж үзсэн нь тохиромжтой, зөв, хэрэгжихүйц хандлагыг баримталсан байгааг харж болохоор байна. Оролцогч талууд нь Стратегийн ач холбогдолтой байдал болон шаардлагатай байдлыг санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрсөн. Зарим талаараа Стратеги нь байгаль орчны салбарын жендэрийн тэгш байдлын хүрээнд хэрэгжих үйл ажиллагаудад оролцогч талуудын хамтын ажиллагааг чиглүүлэх хүрээ болж байна.

Судалгааны үр дүн, олдворуудад үндэслэн Стратегийн дараагийн шатнуудын хэрэгжилтийн сайжруулахад шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулсан.

1. Стратегийн дизайныг сайжруулах буюу Стратегийн логик хүрээг сайжруулах
2. Стратегийг бодлогын баримт бичгийн статустай болгох
3. Төслүүдийн жагсаалтыг боловсруулж, үйл ажиллагаанд зарцуулагдах өртөг, цаг хугацааны хүснэгтийг гаргах
4. ЖҮХ болон яамдуудын жендэрийн зөвлөлийн уялдаа холбоог сайжруулах
5. Донор байгууллагууд, хөгжлийн түншүүдийн оролцоог нэмэгдүүлэх
6. Иргэний нийгмийн оролцоог сайжруулах
7. Стратегийг хэрэгжүүлэх үндэсний механизмыг бий болгох, хангах
8. Мэдлэг дамжуулах үйл явцыг бий болгох, сайжруулах

## “ЗЭЛҮҮД ТАЛ II: МОНГОЛЫН ЗЭРЛЭГ АН АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДАА” ТӨСЛИЙН III ДАХЬ ШАТНЫ СУДАЛГАА



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Монгол орны зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний өрхийн хэрэглээ болоод зах зээл дээрх бүтээгдэхүүний тоо хэмжээ, хуулийн хэрэгжилтийн өөрчлөлт, олон нийтийн хандлагыг тодорхойлох явдал юм. Энэ судалгаа нь дараах зорилтуудтай. Үүнд:

- Зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний өрхийн хэрэглээ, худалдааны тоо хэмжээ, цар хүрээг 2016 оны судалгаатай харьцуулан өөрчлөлтийг үнэлэх
- Байгаль орчныг хамгаалах хуулийн тогтолцоонд иргэдийн итгэх байдал, хандлагыг үнэлэх
- Зэрлэг ан амьтдыг хамгаалахад олон нийтийн оролцоо, дэмжлэг хэр байгааг үнэлэх
- Төслийг давтан хэрэгжүүлэхэд шаардагдах дэлгэрэнгүй баримт бичгийг бүрдүүлэх
- Зах зээлийн болон өрхийн судалгааны хоорондын хамаарлыг тодорхойлох




# 2017

9-р сар

# 2017

12-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар, Хөвсгөл, Ховд, Өмнөговь, Дорнод, Архангай, Сэлэнгэ

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг нь Зэлүүд тал-I төслийг 2006 оноос 2016 он хүртэл хэрэгжүүлсэн ба 2016 оноос Зэлүүд тал-II төслийг Монгол Улстай хамтран хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд зэрлэг амьтан хамгаалал, хууль бус худалдаа, хэрэглээ, зах зээл,

хуулийг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. Төслийн хэрэгжилтийг үнэлэхийн тулд 2006 болон 2016 онд өрхийн судалгаа болон зах зээлийн судалгааг монгол орны хэмжээнд зохион байгуулсан. Судалгаа нь Монгол Улсын зэрлэг ан амьтдыг хамгаалах системд хувь нэмрээ оруулах юм.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Индикаторууд:

1. Улсын хэмжээнд зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний өрхийн хэрэглээ болон түүний зах зээл дэх хүртээмжит байдлын төвшинд ямар өөрчлөлтүүд гарсан байна вэ?
2. Зэрлэг ан амьтдыг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтэнд итгэх иргэдийн итгэлд ямар өөрчлөлтүүд гарсан байна вэ?
3. 2016 оноос хойш зэрлэг ан амьтдыг хамгаалах үйл ажиллагаанд дахь олон нийтийн дэмжлэгт өөрчлөлт ажиглагдаж байна уу?

1. Улаанбаатар, 2. Хөвсгөл, 3. Ховд, 4. Өмнөговь, 5. Дорнод, 6. Архангай, 7. Сэлэнгэ

Тоон арга

Чанарын судалгааны арга

Өрхийн судалгаа

Ярилцлага

Зах зээлийн судалгаа

Ажиглалт

Мета анализ

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- Судалгаагаар зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний өрхийн хэрэглээнд чухал өөрчлөлтүүд гараагүй байна. Учир нь нэг жилийн зайтай энэ судалгааг хийж буй тул тодорхой өөрчлөлт гарахуйц хугацаа бага байсан.
- Зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний өрхийн хэрэглээний төвшин 2016 оны суурь үзүүлэлтээс багассан байна. Айл өрхүүдийн хэрэглэдэг зэрлэг амьтны төрөл зүйл нь өнгөрсөн жил 34 байснаас 25 төрөл болж 26.5%-иар буурчээ. Харин бүтээгдэхүүний төрөл зүйлс 55.8%-аар буурсан ба 414 нэр төрөл байснаас 183 болжээ. Зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний өрхийн хэрэглээ 2015 оноос хойш 20.1%-аар буурсан байна.
- Зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний зах зээл дээрх худалдаа өмнөх зах зээлийн судалгааны үр дүнгээс 2.5%-аар буурч 17.5% болсон байна.
- Монгол орны зэрлэг ан амьтад нь одоо ч анхаарал хандуулах хэмжээнд байгаа нь судалгаагаар харагдаж байгаа ба бүх төвшний хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар талуудын ойлголт, хандлагыг өөрчлөх шаардлагатай байна.

## ДҮГНЭЛТ

Зэрлэг ан амьтад ба хүрээлэн буй орчин нь экосистемийн оршин тогтнолд амин чухал зүйл юм. Монгол орны зэрлэг ан амьтдыг хамгаалах үйл ажиллагааны бүхий л түвшинд стратеги төлөвлөлтийг хийж мониторингийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн байгаль орчны салбарын цаашдын хөгжилд чиглэсэн санал зөвлөмжийг боловсруулсан юм. Судалгааны олдвор, үр дүнд үндэслэн **(i) бодлого, эрх зүйн түвшинд, (ii) үйл ажиллагааны түвшинд, (iii) олон нийтийн түвшинд** чиглэсэн санал, зөвлөмжийг боловсруулсан. Үүнд:

1. Орлоцогч талууд (сүүлийн үеийн шинэ мэдээллээр хангах) хуульд гарсан өөрчлөлт түүний хэрэгжилт, гэмт хэргийн бүртгэл зэрэг мэдээллүүдийг багтаасан тогтвортой эх сурвалжийг бий болгох (зэрлэг амьтдыг хамгаалах мэдээллийн сан) (i)

2. Хуульд орсон өөрчлөлт түүний шалтгаан болон иргэдэд нөлөөлөх нөлөөллийн талаар мэдээллийг олон нийтэд түгээх ажлыг сайжруулах. Бүх хамтрагч талууд ил тодоор мэдээлэл солилцох тухай стратегийг хөгжүүлэх (i)
3. Зэрлэг ан амьтдыг хамгаалах тухай хууль болон түүний хэрэгжилтэд тогтвортой мониторинг хийх (i)
4. Тухайн бүс нутгийн зэрлэг ан амьтантай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх, манлайлж ажиллах, тогтсон хугацаанд тайлагнах, мэдлэг туршлага хуваалцах, мөн бусад нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах (ii)
5. Зэрлэг ан амьтантай холбоотой гэмт хэргийн тухай хууль тогтоомжийн үр нөлөө, ашиглалтын талаар мониторинг хийх, мөн сайн туршлага дээр үндэслэн хууль тогтоомжид оруулж болох өөрчлөлтийг санал болгох (ii)
6. Бүс нутгийн зэрлэг ан амьтадтай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон нийтийн нэгдмэл дуу хоолойг бий болгохын тулд олон нийтийн дунд мэдээлэл хүргэх ажлыг сайжруулах (ii)
7. Хууль бус ан агнуур болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалтай холбоотой асуудлын талаар иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх (iii)
8. Сайн дурын үндсэн дээр орон нутгийн нэгжүүдийг зохион байгуулж аймгийнхаа байгаль орчныг хамгаалах (iii)
9. Орон нутгийн иргэдийн байгаль орчны талаар мэдээлэл авах харилцаа холбооны орчинг бүрдүүлэв (iii)

# АМЬДРАЛЫН БУРУУ ХЭВШЛЭЭС ҮҮДЭЛТЭЙ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХОЁР ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Дэлхийн Банкны Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл (МАСАМ)  
Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Үнэлгээний зорилго нь Нийслэлийн гурван дүүрэгтэй хамтран үнэлгээний хөтөлбөрүүд хэрэгжүүлж, нийгмийн хариуцлагаар дамжуулан төрийн шийдвэр гаргах үйл явц, чанартай үйлчилгээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Хөтөлбөрийн үнэлгээний хүрээнд “Хүүхэд, залуусын дунд эрүүл мэндийн мэдлэг, ойлголт дутагдалтай байгаагаас үүдэлтэй гарах эрүүл мэндийн сөрөг үр дагавар” сэдэвтэй холбоотой асуудлууд дээр нэн тэргүүний ач холбогдол өгөх юм.



# 2017

8-р сар

# 2018

2-р сар

## ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлсэн.

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

“IRIM” Судалгааны Хүрээлэн нь Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн хүүхэд, өсвөр насныхны дунд Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Амьдралын буруу хэвшил (АБХ)-ээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Дэлхийн Банкны “Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд хийсэн. Үнэлгээний үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгож, төрийн болон иргэний нийгмийн байгууллагыг үнэлгээгээр мэргэшүүлэн, төрийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна гэж үзэж байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Төслийн хүрээнд “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөрийг үнэлэхийн тулд дараах хоёр асуулыг дэвшүүлсэн.

- 11-15 насны хүүхдүүдэд АБХ-ээс урьдчилан сэргийлэх орчин нөхцөл (гэр бүл, сургууль, гудамж талбай) бүрдсэн үү?
- 11-15 насны хүүхдүүд АБХ-ын талаар мэдлэг, ойлголт байгаа юу? Амьдралдаа урьдчилан сэргийлэх дадал хэвшил тогтсон уу?

Судалгааны хүрээнд дараах гурван чиглэлээр мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн.

### 1. Салбарын мэдлэг

- Баримт бичгийн судалгаа: Судалгааны тайлан, цахим хуудаснууд
- Экспертийн ярилцлага: Эрүүл Мэндийн Яам, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар, Нийслэлийн Боловсролын Газрын мэргэжилтнүүд -9
- Мэргэжилтний ярилцлага: Дүүргийн Эрүүл Мэндийн Газар, Дүүргийн Эрүүл Мэндийн Төв, хорооны нийгмийн ажилтан, хорооны эмч, сургуулийн захирал, сургуулийн эмч-

30

### 2. Хүүхдийн дуу хоолой

- Кейс судалгаа: 4 хүүхэд (2 эрэгтэй, 2 эмэгтэй)
- Анкетын судалгаа: 6-9 ангийн 2320 хүүхэд
- Фокус бүлгийн ярилцлага: 6-9 ангийн 40 хүүхэд

### 3. Орчин

- Газар зүйн зураглал: 6 сургуулийн 500 метрийн радиус дотор ажиглалт хийж газар зүйн зураглал гаргасан.
- Телевиз ажиглалт: Өсвөр насны хүүхдүүдийн хамгийн их үздэг 3 телевизийн хөтөлбөрт 3 хоногийн ажиглалт хийсэн.
- Сургуулийн гадаад, дотоод орчны ажиглалт: 6 сургуулийн гадна, дотоод орчин

## ҮР ДҮН БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ:

АБХ-ээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийгдсэн явдал нь үндэсний хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн анхны тохиолдол болсон.

Үндэсний хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийгдсэнээр, үнэлгээ хийх арга зүй, аргачлал боловсруулагдсан. Төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагууд энэхүү арга зүй, аргачлалыг ашиглан, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль”-ийн дагуу үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийх боломжтой болсон.

# ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ ТҮГЭЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



Asian Development Bank



IRIM  
INDEPENDENT  
RESEARCH  
INSTITUTE OF  
MONGOLIA



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Хөгжлийн Банк (АХБ)

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам (БСШУСЯ)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь өмнөх зөвлөх үйлчилгээний туршлага дээр тулгуурлан дээд боловсролын сургалтын байгууллагууд бие даан хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой судалгааг хийн ашиглах чадавхийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Энэ хүрээнд:

- Өмнөх зөвлөх үйлчилгээний үр дүн болон үр дагаварыг судлах (хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчийн сэтгэл ханамж, төгсөгчдийг мөшгөх судалгааны үр дүн болон гүйцэтгэлд хяналт хийх, судалгааны тогтвортой байдлыг тандах), гарсан туршлага сургамжид үндэслэн санал, зөвлөмж боловсруулах
- Сургуулийн хэрэгцээ, бодит байдалд тулгуурлан судалгааны аргачлал, дизайныг дээд боловсролын сургалтын байгууллагуудад түгээн дэлгэрүүлэх, сургалт явуулах
- Жендэрийн мэдрэмжтэй мэдээллийг судалгааны холбогдох хэсгүүдэд зайлшгүй тусгах, ач холбогдлын талаар ойлголтыг нэмэгдүүлэх
- Дээд боловсролын сургалтын байгууллагад хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хэрэгжүүлсэн, ашигласан сайн туршлагыг бий болгох.





# 2017


12-р сар

# 2018

3-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.



Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Ховд, Завхан, Говь-Алтай, Архангай, Дорнод, Дорноговь аймгийн дээд боловсролын сургалтын байгууллагууд.

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсад 2016-2017 онд 95 дээд боловсролын байгууллагад 12,740 багш ажиллан, 143,684 оюутан суралцаж байгаа бөгөөд тэдний 91,4 хувь нь нийслэл хотод, 8,6 хувь нь хөдөө орон нутагт суралцаж байна. Дээд боловсролын байгууллагуудын 17 нь төрийн өмчийн, 74 нь хувийн хэвшлийн дээд сургууль, 4 нь гадаадын салбар сургууль байна. Суралцагчдын тоог авч үзвэл төрийн өмчийн их сургуулиудад 91,798, хувийн сургуулиудад 65,075, гадаадын салбар сургуульд 260 оюутан суралцаж байна<sup>1</sup>.

БСШУСЯ-ны статистик судалгаагаар 2015-2016 оны хичээлийн жилд төгсөгчдийн 30.9 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон нь өнгөрсөн онтой харьцуулахад 1.9 хувиар буурсан байна. Хөдөлмөрийн зах зээл дээр өндөр чадвартай мэргэжилтэй ажилтны эрэлт хэрэгцээ их байгаа ч дээд боловсролын салбар

нь оюутнуудад ажил эрхлэх боломжтой чадвар эзэмшүүлэхгүй, зардал багатай, чанар муутай хөтөлбөрөөр боловсрол олгож байгаа сургууль олон байгаа нь ур чадварын үл нийцэлд (mismatch) хүргэж байна.

“Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах” зөвлөх үйлчилгээний төслийг 2015-2016 онд хэрэгжүүлсэн. Энэ төсөл нь их дээд сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа болон төгсөгчдийг мөшгөх судалгааг төлөвлөх, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх аргачлалыг боловсруулан МУИС, МУБИС, Этүгэн их сургууль, Гурван-Эрдэнэ багшийн дээд сургууль, Шинэ анагаах ухааны дээд сургууль, Техник технологийн дээд сургуулиудад туршсан билээ. Одоогоор энэхүү аргачлалыг Монгол Улсын хэмжээнд 95 их дээд сургуулиудад нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байгаа ба энэ үйл ажиллагааны үр дүнд дээд боловсролын сургалтын байгууллагуудын чадавх, онцлогт суурилсан сургалтын гарын авлага, хөтөлбөрийг боловсруулж, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах юм.

1 БСШУСЯ 2017, Дээд боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистик. <http://www.mecss.gov.mn/data/1702/HigherSta1617ab>

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

### **i) Өмнөх зөвлөх үйлчилгээний үр дүнг үнэлнэ.**

Туршилтанд хамрагдсан сургууль болон түгээн дэлгэрүүлэхэд зориулсан сургалтад хамрагдсан хот, орон нутгийн зорилтот сургуулийн ажилтнуудаас судалгаа авч, үр дүнг энэ удаагийн түгээн дэлгэрүүлэх сургалтанд хэрэгжүүлэх, анхаарах шаардлагатай саналуудыг тодорхойлно.

### **ii) Сургалтын хэрэгцээ, дээд боловсролын сургалтын байгууллагуудын чадавхыг тодорхойлно.**

Дээд боловсролын сургалтын байгууллагуудын мэдлэг, чадавхыг тодорхойлох шалгах хуудсыг боловсруулж сургуулиудын чадавхыг үнэлнэ. Үнэлгээний үр дүнд сургуулиудыг бүлэглэж тухайн бүлгийн түвшинд тохирсон сургалтыг зохион байгуулна.

### **iii) Сургалт зохион байгуулна.**

Их, дээд сургуулиудад судалгааг хэрхэн зохион байгуулах, судалгааны үр дүнг сургалтын хөтөлбөр, агуулгын шинэчлэлдээ тусгах, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургууль-үйлдвэрлэлийн түншлэл, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр онолын мэдлэг олгох нэгдсэн сургалт явагдана.

### **iv) Зөвлөгөө, уулзалт, сургалтын үнэлгээ.**

Нэгдсэн сургалтаар олгосон онолын мэдлэгийг баталгаажуулах, сургуулиуд өөрийн онцлогтоо нийцүүлэн ашиглах, нэгдмэл ойлголттой болох

зорилгоор давтан сургалтыг зохион байгуулна.

### **v) Туршлага солилцох**

Сургалтын явцад сургуулиудын хооронд туршлагаа солилцох үйл ажиллагааг зохион байгуулна. Энэ ажилд IRIM Судалгааны Хүрээлэн ба “Дээд Боловсролыг Шинэчлэл” төсөл дэмжлэг үзүүлж ажиллана. Энэхүү үйл ажиллагаа нь сайн дурынх байх бөгөөд сонирхол илэрхийлсэн сургуулиудыг хамруулж зохион байгуулна.

### **vi) Сайн туршлагыг харуулсан нэвтрүүлэг бэлтгэх**

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хэрэгжүүлсэн болон хэрэглэсэн дээд боловсролын сургалтын байгууллагуудын дунд арга хэмжээ зохион байгуулах, мөн богино хэмжээний бичлэг, нэвтрүүлэг хийж шалгарсан байгууллагуудын сайн туршлагыг баримтжуулна.

## ҮР ДҮН, ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төслийн үр дүнд Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагуудад төгсөгчдийг мөшгөх судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг бие даан хэрэгжүүлэх чадавх бий болох, судалгааны мэдээлэлд тулгуурлан сургалтын хөтөлбөрөө шинэчилэх, сургалт-үйлдвэрлэлийн холбоо-хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюутанд ажил мэргэжлийн зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээг хүргэхэд ашиглах чадавхыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

# “НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН СУРГУУЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Японы Хүүхдийг Ивээх Сан (ЯХИС)

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний зорилго нь ЯХИС-аас 2015-2018 онд хэрэгжүүлсэн төслийн үр дүн, хэрэгжилтийн явцыг нотолгоонд суурилсан арга зүйгээр үнэлж, дүн шинжилгээ хийхэд оршино.

Судалгааны хүрээнд

1. Төслийн баримт бичиг (1, 2, 3 дахь жилийн)-т дурдсан бүрэлдэхүүн хэсэг бүрийн зорилт, хүлээгдэж буй үр дүнгүүдийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт болон суурь судалгааны зөвлөмжүүдийн хэрэгжилтийг үнэлэх;
2. Төслийн сайн туршлагууд, төслийн хэрэгжилтийн явцад учирч байсан хүндрэл бэрхшээл, сургамжууд, даван туулсан арга замыг тодорхойлох;
3. Төслийн хэрэгжилтийн үр дүнд нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд бэлтгэгдсэн байдал болон дасан зохицох чадварт гарсан өөрчлөлт, үр нөлөөг үнэлэх зорилготой.



# 2017

12-р сар

# 2018

2-р сар

## ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлсэн.

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ


ЯХИС, Боловсрол Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамтай хамтран Японы Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийг гурван жилийн (2015-2018) хугацаатай хэрэгжүүлж байна. Энэ төсөлд Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн нийт 24 сургуулийг сонгон авч хамруулсан. Төслийн зорилго нь “Сургуульд дасан зохицох хөтөлбөр”-ийн

тусламжтайгаар алслагдсан дүүргийн төрийн өмчийн сургуулиудын 1-р ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх юм. Энэхүү зорилгын хүрээнд сургуулийн удирдлага, багш, эцэг эх болон төрийн бодлогын түвшинд үйл ажиллагаа явуулсан.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны ерөнхий загвар нь ‘туршилтын бус’ (‘non-experimental’) загвар бөгөөд үүнийг доорх дүрсэд харууллаа.

Дүрс 1. Туршилтын бус загвар



Судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан цуглуулсан.

Тоон аргуудыг төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд шаардлагатай тоон үзүүлэлтийг гарган авахад ашигласан. Мөн төслийн үр дүнд эцэг, багш нарын мэдлэг, хандлага, дадалд гарсан өөрчлөлтийг үнэлэхэд тоон судалгааны үр дүнг ашигласан. Харин чанарын судалгааны мэдээллийг төслийн хамааралтай байдал болон хамтын ажиллагаа, өөрчлөлт, үр нөлөөг тодорхойлоход ашигласан. Мөн төслийн үр дүнд бий болсон сайн туршлагуудыг илрүүлэх, төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг тодорхойлоход чанарын мэдээлэл гол эх сурвалж болсон.

Эцсийн үнэлгээнд төслийн дизайн болон зорилготой уялдуулан олон шатлалт түүврийн аргыг ашигласан. Нэгдүгээрт, үнэлгээний

мэдээллийг цуглуулах сургуулиудыг сонгон авсан. Үүний дараа, судалгаанд оролцогчийн бүлгийг тодорхойлж, тэдгээр бүлгээс түүвэрлэлт хийсэн.

Үнэлгээнд зорилтот сургуулийн нийт 504 багш, 500 эцэг эхчүүдийг хамруулсан ба 3 фокус бүлгийн ярилцлага, 38 ганцаарчилсан ярилцлага, 10 кейс судалгааны мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийсэн.

## ҮР ДҮН БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төсөл нь Жилийн тайланг бичих явцад хэрэгжиж байсан тул эцсийн үр дүн хараахан гараагүй байна.

## ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮД

# НИЙСЛЭЛИЙН ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН БОДЛОГО, БАРИМТЛАХ ЖУРАМ, ТӨСЛИЙН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ



**IRIM**  
INDEPENDENT  
RESEARCH  
INSTITUTE OF  
MONGOLIA



### ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь нийслэлийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, баримтлах журам, төслийн удирдлагыг сайжруулах аргачлал боловсруулахад оршино.



# 2017

11-р сар

# 2018

3-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

*Энэхүү төсөл нь Улаанбаатар хотод хэрэгжиж байна.*

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Нийслэлийн түвшинд Төр Хувийн Хэвшлийн Түншлэлийн (ТХХТ)-ийн бодлого, зорилгыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, улс орны болон нийслэлийн хөгжлийн бодлогын төлөвлөлт, түншлэлд оролцогч талуудын чадавхид тулгуурлан цаашдын хөгжлийн төслүүдийг тодорхойлох бодит хэрэгцээ зайлшгүй байгаа юм. Өнөөгийн байдлаар нийслэлийн түвшинд төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын бичиг баримт болон зохицуулах журам байхгүй байна. Мөн нийслэлийн төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хариуцан ажиллах чиглэлээр талуудын хамтын ажиллагаа сул, талуудын оролцоо тодорхойгүй, нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын дунд нэгдмэл ойлголт байхгүй байна. Энэ нөхцөл байдлаас үүдэн энэхүү төслийн хүрээнд нийслэлийн ТХХТ-ийн бичиг баримтыг боловсруулах, нэгдсэн бодлого, журам боловсруулах, оролцогч талуудыг чадавхижуулах үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага бий болоод байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээний зорилго нь Нийслэл хотын төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, баримтлах журам, төслийн удирдлагыг сайжруулах аргачлал боловсруулах бөгөөд дараах ажлуудыг гүйцэтгэсэн:

- Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;
- Холбогдох бодлогын баримт бичгүүдийг боловсруулах;
- Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх.

## ҮР ДҮНГҮҮД ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төслийн үр дүнд, ТХХТ-ийн талаарх өнөөгийн хууль тогтоомж, институцийн бүтэц, зохион байгуулалт, журам, аргачлал, хэрэгжүүлсэн төслүүдэд дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэсэн. Нөхцөл байдлын шинжилгээ хийх ажлын хүрээнд

оролцогч талууд болох НЗДТГ, Нийслэлийн Үйлдвэрлэл Инновацийн Газар (НҮИГ) болон Улаанбаатар Хотын Хөгжлийн Корпораци (УБХК)-ыг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд ТХХТ-ийн өнөөгийн байдал болон ТХХТ-ийн төслийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдлийг тодорхойлсон.

Нөхцөл байдлын шинжилгээнд суурилан Нийслэлийн ТХХТ-ийн бодлого, журмын төсөл боловсруулсан ба бодлого болон журмын төслүүдэд холбогдох талуудаас санал авсан. Мөн түүнчлэн ТХХТ-ийн талаарх ойлголт, энэ чиглэлийн олон улсын туршлага, нэн тэргүүнд санхүүжилт шаардлагатай хөгжлийн төслүүдийг тодорхойлох чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтад нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд болон НЗДТГ, НҮИГ, УБХК зэрэг талуудын албан хаагчдыг хамруулсан. Сургалт, хэлэлцүүлгийн үеэр гарсан санал санаачлага, бодлого, журмыг нэгтгэн боловсруулан захиалагчид хүлээлгэж өгнө.

Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан баримт бичгүүдийг батлуулах ажлыг НЗДТГ хариуцан гүйцэтгэнэ.

**“21-Р ЗУУНЫ АРДЧИЛАЛ: СОРИЛТУУД  
БА ЦААШДЫН ХАНДЛАГА” СЭДЭВТ  
ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ**



**ЗАХИАЛАГЧИЙН НЭР**

World Society Foundation - Дэлхийн Нийгмийн сан

**ТӨСЛИЙН ЗОРИЛГО**

“21-р зууны ардчилал: Сорилтууд ба цаашдын хандлага” сэдэвт олон улсын бага хурал нь ардчиллын асуудлаар сонирхон судалдаг эрдэмтэд, судлаачдын бүтээл туурвил, онолын болон эмпирик судалгааны үр дүн, ололт амжилтуудыг мэдээллэх, харилцан солилцох, хамтран ажиллах, туршлага хуваалцах зорилготой юм.




# 2017

9-р сар

# 2018

8-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Дэлхийн Нийгмийн сан байгууллага нь 1982 онд нийгмийн судалгааны төслүүдийг санхүүжүүлэх, дэмжих зорилгоор байгуулагдсан. 2003 оныг хүртэл нийгмийн интеграцийн үйл явц, дэлхий дахины системийн зардал (дэлхийн соёл, дэлхийн эдийн засаг, дэлхийн улс төр, засгийн газар хоорондын систем) зэрэг сэдвээр судалгааны төслүүдийг санхүүжүүлж байсан. Сүүлийн жилүүдэд глобал шинжтэй нийгмийн асуудлуудын хүрээнд олон улсын хурлыг зохион байгуулах, судлаачдын судалгааны ажлыг дэмжих, тэтгэлэг олгох чиглэлээр түлхүү ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд нийт найман удаагийн хурал зохион байгуулсан ба энэ удаагийн “21-р зууны ардчилал: Сорилтууд ба цаашдын хандлага” сэдэвт хурал нь Монголд 2018 оны 7 сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна. Азийн улс орнуудаас ардчилсан дэглэмд шилжсэн улс орнууд олон бий. Энэ дундаас Монгол Улс нь нэг намын системтэй коммунист дэглэмээс ардчилсан дэглэм рүү шилжсэн улсуудын нэг юм. 1980-аад оны сүүлээр Монгол Улсад өөрчлөлт шинэчлэлийн үзэл санаа улам гүнзгийрч ардчилсан шинэчлэл

хийхийг шаардан эрх баригч хүчнийг эсэргүүцсэн ардчилсан хөдөлгөөний идэвхитэй тэмцлийн үр дүнд тайван замаар ардчилалд шилжсэнээрээ ихээхэн онцлогтой билээ. Манай орны энэ туршлага, сургамж нь шинэ зууны ардчиллын сорилт, хөгжил төлөвшлийн чиглэлээр олон улсын хурал зохион байгуулах гол нөхцөл болж байна.

### ХУРЛЫН АГУУЛГА:

21-р зууны Ардчиллын явц, хөгжил төлөвшилд тулгарч буй сорилтууд, цаашдын замналын талаар гадаадын болон манай орны судлаач, эрдэмтэд өөрсдийн байр сууриа ярилцан хэлэлцэх замаар хуралд оролцоно. Хурал нь дараах гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

1. **Хот, хөдөөгийн ялгаа ба ардчилал** (хот, хөдөөгийг ялгаа нь ардчиллын үйл явцад нөлөөлөх нь, Азийн орнуудын хот, хөдөөгийн ялгаатай бүс, газар нутгийн улс төрийн ялгаа, хот хөдөөгийн мэдээлэл авах эрх, хүний эрх, жендэр, сонгогчдын зан үйл, улс төрийн намууд болон сонгуулийн систем, хот, хөдөөгийн



нийгмийн эв нэгдэл)

2. **Иргэний нийгэм ба ардчилал** (ардчилсан засаглалд иргэний нийгмийн үүрэг, ардчиллыг идэвхжүүлэхэд иргэний нийгмийн оролцоо, сайн засаглал, иргэдийн оролцоо, олон нийтийн итгэл үнэмшил, Ази дахь ардчиллыг бэхжүүлэхэд иргэний нийгмийн үүрэг)
3. **Олборлох эдийн засаг, нөөц баялаг ихтэй улс орнууд ба ардчилал** (Засаглалын ил тод байдал, хариуцлагын тогтолцоо (авлига), ардчилал нь байгалийн нөөц баялагт тулгуурласан дэлхийн эдийн засгийн системд хэрхэн ажиллаж байна вэ, байгалийн баялаг, ардчилал, авлигын харилцан хамаарал, ардчилсан засаглал болон үндэстэн дамнасан корпорациуд; Гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал ба улс төрийн дэглэм)

Хуралдааны үндсэн болон дэд сэдвүүдийн агуулгын хүрээнд сонирхсон судлаачид судалгааныхаа хураангуйг ирүүлсэн. Эрдмийн зөвлөл нь судалгааны хураангуй болон ажлыг шалгаруулан, тэтгэлэг авах судлаачдыг сонгоход гол үүрэгтэй оролцож байна. Одоогоор тэтгэлэг

авах судлаачдаа эцэслэх үйл явц явагдаж байна. Хурлын сэдэв бүр дээр нэг үндсэн илтгэгч байх юм.

“Хот, хөдөөгийн ялгаа ба ардчилал” салбар хуралдааны үндсэн илтгэгчээр Улс Төрийн Боловсролын Академийн Удирдах зөвлөлийн дарга, ХБНГУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Ганбат ажиллана. “Иргэний нийгэм ба ардчилал” салбар хуралдааны үндсэн илтгэгчээр Калифорнийн Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны профессор Стивен Фиш ажиллана. “Олборлох эдийн засаг, нөөц баялаг ихтэй улс орнууд ба ардчилал” салбар хуралдааны үндсэн илтгэгчээр Австрали улсын Гриффит Бизнесийн Сургуулийн олон улсын бизнес болон Ази тив судлалын факультетын доктор/илтгэгч Тапан Саркер ажиллана.

### **ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ:**

Хурал нь 2018 оны 7-р сард зохион байгуулагдах ба жил бүр шалгарсан илтгэлүүдийг нэгтгэн хурлын эмхэтгэл гаргадаг. Энэ удаагийн хурлын эмхэтгэл нь ардчиллын чиглэлээр судлаачдын хувьд маш сонирхолтой бүтээл болно гэж төслийн баг харж байна.

# БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙТ БАЙДЛЫН ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГАА



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Транспаренси Интернэшнл-Монгол ТББ

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Бизнесийн ёс зүйт байдлын хөтөлбөр болох төсөл нь ил тод байдал, ёс зүй, хариуцлагыг сайжруулах замаар бизнесийн орчны авлигыг бууруулах үндсэн зорилготой.

Түүнд хүрэхийн тулд Монгол Улсад хэрэгжүүлж буй “Бизнесийн ёс зүйт байдлын хөтөлбөр” судалгаа нь (а) манай улсын бизнесийн орчны ёс зүйт байдлыг баримт бичгийн нотолгоон дээр тулгуурлан сайжруулах (б) шинэчилсэн хөтөлбөрийг дэвшүүлэн хувийн салбар доторх болон салбараас гарах авлигыг бууруулах зорилготой.



# 2017

10-р сар

# 2018

6-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар

## ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Одоогийн байдлаар дэлхийн ихэнх улс оронд бизнесийн буюу хувийн салбарт авлигатай тэмцэх нэгдсэн цогц үнэлгээний тогтолцоо байхгүй байна. Транспаренси Интернэшнл олон улсын байгууллага нь 2016 оноос эхлэн уг орон зайг нөхөх зорилгоор бизнесийн орчин дахь ёс зүйт байдлыг сайжруулах үүднээс улс орон бүрд “Бизнесийн ёс зүйт байдлын хөтөлбөр” судалгааг хэрэгжүүлж эхэлсэн байна. Мозамбик, Турк, Итали, Камбож зэрэг улсуудтай зэрэгцэн 2018 онд анх удаагаа уг хөтөлбөрийг үнэлэх ажил Монгол Улсад хийгдэж байна.

## ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Энэхүү судалгаа Транспаренси Интернэшнл олон улсын боловсруулсан арга, аргачлалын дагуу баримт бичгийн судалгааг улс орон бүрд хийгддэг. Уг хөтөлбөр тухайн улсын төр, хувийн салбар болон иргэний нийгмийн уялдаа холбоог 15 хэсэг, 51 индикаторын хүрээнд авч үздэг ба 3 салбарт ерөнхий үнэлгээг боловсруулдаг. Мөн уг судалгаа дэлхийн улс орнуудыг хооронд нь харьцуулдаггүйгээрээ онцлог.

## ҮР ДҮНГҮҮД:

Судалгааны явцад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах салбар бүрийн 9 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй Зөвлөх Бүлгийг үүсгэн байгуулж, анхдугаар уулзалтыг 2017 оны 11 сард зохион байгуулсан юм. Уг Зөвлөх Бүлэгт төрийн салбар, бизнесийн салбар, иргэний нийгмийн төлөөлөл багтсан болно. Одоогоор судалгааны ажил явагдаж байна.

## ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ:

“Бизнесийн ёс зүйт байдлын хөтөлбөр” судалгаа 2018 оны 06 сарын 04-нд олон нийтэд танилцуулах ба олон улсад хэвлэгдэнэ. Уг судалгааны үр дүнд тулгуурлан хувийн салбар дахь авлигыг бууруулах шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулж, хувийн салбар доторх болон салбараас гарах авлигыг бууруулахад чиглэсэн шат дараалсан үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх болно.

# НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ТӨСВИЙН БУУРАЛТЫН ҮР НӨЛӨӨНИЙ ШУУД МОНИТОРИНГ



## ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь нийгмийн халамжийн хөтөлбөрийн өөрчлөлт, эмзэг бүлгийн өрхүүдэд нийгэм, эдийн засгийн ямар үр нөлөө үзүүлж байгааг үнэлэхэд оршино. Энэхүү үр нөлөөг үнэлэхийн тулд дараах судалгааны асуултуудын дагуу мэдээлэл цуглуулж байна. Үүнд:

- Мониторингийн хугацаанд нийгмийн халамжийн зарцуулалт, ялангуяа хүүхдийн мөнгөний хөтөлбөртэй холбоотой ямар шийдвэрүүдийг Монгол Улсын Засгийн Газраас гаргаж байна вэ?
- Тэдгээр шийдвэрүүд нь төвийн болон орон нутгийн засаг захиргааны түвшинд хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжилтийн явцад гарч байгаа бэрхшээл болон үйл явцын асуудал гарч байна уу?
- Тэдгээр шийдвэрүүд нь эмзэг бүлгийн хүмүүст хоол хүнс, эрүүл мэнд, аюулгүй байдал болон хүүхдүүдийн боловсролд зарцуулах зарчимд нөлөө үзүүлж байна уу?
- Хүүхдийн сайн сайхан байдалд ямар нөлөө үзүүлж байна вэ?




# 2017

9-р сар

# 2018

9-р сар

## ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Баянхонгор аймаг  
(Гурванбулаг сум,  
Эрдэнэцогт сум)

Улаанбаатар хот  
(Баянзүрх дүүргийн 9-р  
хороо, Сонгинохайрхан  
дүүргийн 7-р хороо)

### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

“Хүүхдийн мөнгө” хөтөлбөр нь 2005 оны 1 дүгээр сараас 2017 оны 12 дугаар сар хүртэл манай улсын нийт хүүхдийг хамруулж байсан боловч Олон Улсын Валютын Сантай хийсэн гэрээний дагуу уг хөтөлбөрт өөрчлөлт орж Монгол улсын нэн ядуу буюу нийт өрхийн 40 хувьд хүүхдийн мөнгө олгохоор тохиролцсон. Мөн Засгийн Газар олон удаа солигдох, улсын төсөв, гадаад гэрээ хэлцэлтэй холбоотойгоор хүүхдийн мөнгө тогтмол олгогдохгүй тасалдах, нийгмийн зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй байх зэрэг асуудал үүссэн нь энэхүү төслийг хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

### ТӨСЛИЙН ДИЗАЙН

Арга зүйн хувьд энэхүү судалгааг дараах 2 түвшинд гүйцэтгэж байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн бодлогын өөрчлөлтийг судлах
  2. Өрх болон хүүхдэд нийгмийн халамжийн бодлого ямар үр нөлөө үзүүлж байгааг судлах
- Мониторингоор нийт 9 шалгуур үзүүлэлтээр хэмжиж байгаа бөгөөд анхдагч мэдээллийг тоон ба чанарын судалгааны аргаар цуглуулж байна. Тоон аргаар сар бүр зорилтот өрх, судалгаанд хамрагдаж байгаа хүмүүсээс асуумж мэдээлэл авна. Харин ганцаарчилсан ярилцлагыг дараах 2 түвшинд хийж байна.

1. Улирал бүр судалгаанд хамрагдаж байгаа

- судалгаанд хамрагдаж байгаа хүмүүстэй 9 шалгуур үзүүлэлтийн хүрээнд ярилцлага хийх
2. Нийгмийн халамжийн хөтөлбөр ялангуяа “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн бодлогын өөрчлөлт, хэрэгжилтийн талаар салбарын мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан ярилцлага хийх

Хоёрдогч мэдээллээр нийгмийн халамжийн бодлого, ялангуяа “Хүүхдийн мөнгө” хөтөлбөртэй холбоотой бодлогын баримт бичиг, судалгаа, тоо баримтыг судалж байна.

Мэдээлэл цуглуулах талбарыг сонгохдоо хүн амын нягтрал, ядуурлын индекс, хот хоорондын зай, бэлчээрийн мал аж ахуй, гар аргаар алт олборлодог эсэх үзүүлэлтүүдийг харгалзан захиалагчтай тохиролцсоны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сум, Эрдэнэцогт сум, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороонд тус мониторингийг гүйцэтгэж байна. Харин зорилтот өрхүүдийг сонгохдоо өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа, өрхийн хүүхдийн тоо, өрх толгойлсон эцэг/эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй эсэхийг харгалзан санамсаргүй түүврийн аргаар сонгов.

### ҮР ДҮН

Энэхүү төсөл нь IRIM Судалгааны Хүрээлэнгийн жилийн тайланг бичих явцад хэрэгжиж байгаа ба 2018 оны 9 сард эцсийн үр дүн гарах тул энэ хэсэгт мэдээлэл оруулах боломжгүй байна.